



Бөхөнгийн экологи болон хамгаалалтай холбоотой мэдээлэл, санал бодлоо солилцох зургаан хэл дээрх хэвлэл

## АГУУЛГА

## Өгүүллүүд

Эва Клебелзберг. “Алтин Дала” Байгаль Хамгаалах Санаачлага: Тал хээрийн экосистем болон соргог бөхөн хамгаалах урт хугацааны төсөл

1

## Шинэ мэдээ

3

## Бөхөнгийн тухай мэдээ

Алина Бекирова Сайга-Сага. Төв Ази. 27.06.2008.

6

## Өгүүллүүд

<sup>1</sup>Б.З. Дуйсекеев, <sup>2</sup>С.Л. Скляренко. Казахстаны бөхөн хамгаалал

7

Федосов.В. Бөхөн ёсгөн үржүүлэх төв-Экологийн боловсролын төв

9

Косбергенов.М. Узбекистаны Арап тэнгисийн зүүн эрэг дэх бөхөнгийн популяцийн хамгаалал

10

Манджиеев Х.В., Мойсейкино Л.Г. Европын бөхөнгийн популяцији дахь альбинизм

10

## Төслийн эргэн тойронд

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол бөхөн төсөл.

11

Степной дархан газрын үл ажиллагааны шинэ чиглэл

12

Лондонгийн Эзэн хааны коллежийн төслийн тухай шинэ мэдээ

12

Надад ид шидгэй үлгэр ярьж өгөөч

13

Устюртын эмэгтэйчүүдийн нэмэлт орлогын эх үүсвэр болох уламжлалт хатгамал

13

Узбекистанд бөхөнгийн дархан цаазат газрыг үнэлэх шинэ төсөл өхөллээ

14

## Сүүлийн үед хэвлэгдсэн бөхөнгийн талаарх нийтлэлийн тойм

14

## Зарлал

15

Бөхөн хамгаалах холбоо (БХХ)-ны жижиг тэтгэлгийн хөтөлбөр 2008

15

## БХХ бол бөхөн хамгаалал дахь MOU-ийн мониторинг хийж байна

16

CMS Харилцан ойлголцын санамж бичгийн 2008 оны I-VI-р сарын хэрэгжилтийн тайлан

## “Алтин Дала” Байгаль Хамгаалах Санаачлага: Тал хээрийн экосистем болон соргог бөхөн хамгаалах урт хугацааны төсөл

“Алтин Дала” Байгаль Хамгаалах Санаачлага (ADCI) нь томоохон хэмжээний төсөл бөгөөд цөлөрхөг хээрийн экосистем, тал хээрийн хойд хэсэг төдийгүй уг бус нутгийн шүхэр зүйл болох нэн ховор соргог бөхөн (*Saiga tatarica tatarica*), хавтгаалж шувууг (*Vanellus gregarius*) хамгаалахад чиглэгдсэн үл ажиллагаа явуулдаг. Уг санаачлагыг Казахстаны засгийн газар, Казахстаны Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах Холбоо (ACBK), Франкфуртын Амьтан Судалын Нийгэмлэг (FZS),

Нэгдсан вант улс дахь Шувуу Хамгаалах Нийгэмлэг (RSPB), болон Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн олон улсын хотөлбөрийн газар хамтран хэрэгжүүлж байна. Казахстаны Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах Холбоонд 2007 оны эхнээс ажиллаж буй хоёр мэргэжилтний урт хугацааны хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар Олон Улсын Нуудэл, Хөгжлийн Германы Төв нь уг төслийн ажиллагааг дэмжин ажиллаж байна.

“Алтин Дала Байгаль Хамгаалах Санаачлага”-н (“алтин дала” гэдэг нь Казахаар “алтан тал” гэсэн утгатай) 2006 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд Үржлийн үеийн эм бохон. Бетбакдала. Зургийг Эва Клебелзберг

Бетбакдала дахь бөхөнгийн тархац нутгийг хамруулан ойролцоогоор 55 сая га газар нутгийг (Францийн газар нутгийн хэмжээ) эзэлдэг байна. Уг санаачлагын үндсэн зорилго нь:

- Бетбакдала дахь бөхөнгийн популяци, түүний амьдрах орчинд ирээдүйд учирч болох аюул занал, мөн хулгайн ан, амьдрах орчны доройтол болон хуваагдал зэргийг тогтоох
- Янз бүрийн статустай тусгай хамгаалалттай газар нутгуудын сүлжээг байгуулан бөхөн болон бусад түхүүр зүйл болох хулан адтуу, хар сүүлтий, хонин тоодог, хавтгаалжны амьдрах орчин, нүүдлийн зам, коридорыг хамгаалах
- Орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх бусад холбогдох байгууллагын оролцоог сайжруулах
- Эдгээр хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд Казахийн тал болон цөлөрхөг хээрийн экосистем түүнд амьдарч буй үзүүлүүдийн талаарх суурь мэдээллийг цуглуулах
- Тал хээр, бөхөн хамгааллын талаарх мэдлэгийг орон нутгийн болон олон улсын хэмжээнд нэмэгдүүлэх

Үргэлжлэл 2-р хуудсанд.

Ева Клебелзберг, Altyn Dala Conservation Initiative & Association for the Conservation of Biodiversity of Kazakhstan (ACBK), [eva.klebelzberg@acbk.kz](mailto:eva.klebelzberg@acbk.kz)

Эрхлэн гаргагчид. China: Dr A. Kang, WCS China ([ylgling@online.sh.cn](mailto:ylgling@online.sh.cn)) & Dr Li Lishu, WCN-China ([lli@wcs.org](mailto:lli@wcs.org)); Kazakhstan: Professor A. Bekenov & Dr Yu.A. Grachev, Institute of Zoology ([terio@nursat.kz](mailto:terio@nursat.kz)); Mongolia: Dr B. Lhagvasuren, Institute of Biology ([ecolab@magicnet.mn](mailto:ecolab@magicnet.mn)) & Yo.Onon, WWF-Mongolia ([mpo-species@wwf.mn](mailto:mpo-species@wwf.mn)); Russia: Professor Yu. Arylov, Centre for Wild Animals of the Republic of Kalmykia ([kalmsaigak@elista.ru](mailto:kalmsaigak@elista.ru)) & Dr A. Lushchekina, Institute of Ecology & Evolution ([rusemabcom@gmail.com](mailto:rusemabcom@gmail.com)); Turkmenistan: Dr. D.Saparmuradov, National Institute of Deserts, Plants and Animals ([saparmuradov@mail.ru](mailto:saparmuradov@mail.ru)); Uzbekistan: Dr E. Bykova & Dr A. Esipov, Institute of Zoology ([esipov@sarkor.uz](mailto:esipov@sarkor.uz)); UK: Dr E.J. Milner-Gulland, Imperial College London ([e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk)).  
Манай хэвлэлийн зургаан хэлний аль нэг дээр аливаа санал хүсэлтийг [esipov@sarkor.uz](mailto:esipov@sarkor.uz), [saigaconservationalliance@yahoo.co.uk](mailto:saigaconservationalliance@yahoo.co.uk) хаягуудаар, эсвэл дээрх гишүүдийн дурын хаягаар хүлээн авна. Жилд хоёр дугаар гарна

Хэвлэлийн эхийг pdf хэлбэрээр, Хятад, Англи, Казах, Монгол, Орос, Узбек хэлдээр [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com), <http://saigak.biodiversity.ru/publications.html>, [www.icsc.org.uk/saiganeWS.htm](http://www.icsc.org.uk/saiganeWS.htm), <http://www.wildlifewarden.net/wcs/mini/Saiga-Chinese.pdf> хаягуудаар авч болно

Хэвлэлийг санхүүжүүлэгч:



Нэмэлт санхүүжилтийг:





1-р хуудасны ургэлжлэл

**Төслийн ололт амжилт:**

**Бөхөн хамгаалал:** ADCI санаачлага нь байгаль хамгаалагчдын 3 бүлэг байгуулж машин, майхан, дуран, болон бусад шаардлагатай хээрийн багаж төхөөрөмжөөр тоноглосон. Эдгээр байгаль хамгаалагчид нь улсын байгаль хамгаалах хээрийн багийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, сургуулийн сургачид ба орон нутгийн удирдлагуудтай (ахимаг насны бүлэг хүмүүс) хамтран ажиллахаад замаар ёсвөр насны багачуудыг хулгайн анд татагдан орохоос сэргийлэх, мөн төслийн мониторинг системийн хүрээнд түлхүүр зүйл амьтдын талаарх мэдээллийг цуглуулах үүрэгтэй.



ADCI төслийн Бетпакдаалах дахь байгаль хамгаалагчид  
Зүргийг Орчен Шайтухабетов

**Бөхөн төллөдөг нутгийг тогтоов:** Сүүлийн саруудад гаргасан төслийн хамгийн гайхалтай амжилт бол бөхөн олноор янзагалдаг нутгийг олж тогтоон хамгаалсан явдал бөгөөд энэ нь Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн хувьд сүүлийн жилүүдэд тодорхойлсон хамгийн чухал төллөдөг нутаг юм. Сүүлийн жилүүдэд Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн төллөдөг нутаг жижиг хэсгүүдэд хуваагдсан ба бөөнөөр төллөдөг нутаг ажиглагдаагүй юм. Гэвч гурван долоо хоногийн өмнө ADCI төслийн хээрийн багийн гишүүд доод тал нь 4000 орчим шаргачин хориод хоногийн дотор нэгэн зэрэг бөөнөөр төллөсөн газар нутгийг олж тогтоосон. ADCI төслийн байгаль хамгаалагчид, судлаачид, Иргиз-Тургае Резерватын орчмын улсын байгаль хамгаалгычидтай хамтран уг сургийн орчим ажиглалт хийсэн бөгөөд хулгайн ан болон хүний нөлөөг багасгахын тулд тухайн орчмын замыг хаасан. Тэд сургийн зан төрх, тоо толгой, тархац нутгийн талаарх мэдээллийг цуглуулсан. Энэ экспедицийн үеэр өөр гурван бөхөнгийн багахан сургийн төллөж буй нутгийг тогтоосон. Төллөсөнөөс хойших хэдэн саруудад ADCI төслийн байгаль хамгаалагчид уг сургийг дагахыг оролдсон бөгөөд энэ нь бөхөнгийн нүүдэл болон бэлчээр ашиглалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулахад нэмэр болно.

ADCI төсөл одоогоор Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн үнэлгээг хийдэг арга зүйг сайжруулах тал дээр Казахстаны Ойн Аж Ахуй, Ангийн Зөвлөлийг дэмжин ажиллаж байгаа ба ингэснээр бөхөнгийн тоо толгойн талаарх бодит тоог урт хугацаанд авах боломжтой болно. Орчин үеийн арга зүй, багаж техник тухайлбал GPS, өндөр хэмжигч дутагдалтайн улмаас сүүлийн жилүүдэд хийдэж буй тооллогын үр дүн тийм ч бодит биш юм. Гээн хэдий ч эдгээр тооллогын мэдээ нь бөхөнгийн популяцийн чиг хандлагыг тодорхойлоход чухал мэдээг бидэнд өгч байна.

**Тусгай хамгаалалттай газар нутаг байгуулав:** ADCI төслийн хүрээнд бөхөн зусдаг болон төллөдөг 500,000 га талбай бүхий тал хээр, чийглэг газрыг застгийн газарт шахалт, дэмжлэг үзүүлэх шугамаар “Тусгай хамгаалалттай Газрын Хөгжлийн Хөтөлбөрт” багтаан оруулсан. Төслийн баг хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдлын нөөцийг тогтоох шинжлэх ухааны судалгааны төлөвлөгөөг боловсруулан санхүүжүүлсэн. Одоогоор бид эдийн застгийн болон арга техникийн судалгааг хийж эхлээд байна. Бид тусгай хамгаалалттай газар нутгийг 2010 онд эцэслэн байгуулахаар төлөвлөж байна.

ADCI төсөл нь Казахстаны тусгай хамгаалалттай газар нутгийн системд багтаагүй бөхөн болон бусад биологийн олон янз байдлын хувьд нэн чухал экосистемийг “дутагдалтай зүйлийн дүн шинжилгээ” хийх замаар тодорхойлон засгийн газрын “Тусгай хамгаалалттай газрын хөгжлийн хөтөлбөр”-т оруулахаар ажиллаж байна. Энэ зун Алтин Дала төслийн баг бөхөн хамгаалахад юу шаардлагатай олж мэдэхийн тулд эдгээр газрууд руу нэг юмуу түүнээс дээш тооны экспедиц зохион байгуулахаар ажиллаж байна. Алтин Дала төслийн зорилго бол Бетпакдалагийн бөхөнгийн тархац нутгийн хэмжээнд 3-4 сая га талбай бүхий тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ байгуулах явдал юм.

**Хамгаалал төлөвлөхөд экосистемийн талаарх ойлголт:**

Дэлхийн бөмбөрцгийн хойд хэсгийн тал хээр, цөлөрхөг хээрийн экосистем болон тэдгээрт тархсан биологийн олон янз байдал өнөөг хүртэл муу судлагдсан байна. Энэхүү цөлөрхөг болон тал хээрийн амьтан, ургамлын бүрдэлд соргог бөхөн чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир нь бөхөн тал хээрийн ургамлын үр тоосыг алс зайд тараан, баасаараа хөрсийг бордон, ургамлын үрийг хөрөнд гишгэлэн суулгаж ургах нөхцлийг бүрдүүлнэ. Гэвч бөхөнгийн бэлчээрт үзүүлэх нөлөө алдагдсанас болж тал хээрийн ургамлын зүйлийн олон янз байдал дорийтон хөрсний шинж чанар муудаж байна. RSPB болон ACBK-ийн сүүлийн үеийн судалгаагаар нэн ховордож буй (IUCN 2007) хавтгаалж шувуу (*Vanellus gregarius*) болон зэрлэг туруутан амьтдын бэлчээрт үзүүлэх нөлөө хоорондоо нарийн уялдаа холбоотойг болохыг харуулжээ. Казахстан дахь энэхүү ховор шувууны үржлийн гол нутаг жигд бус өвстэй газар бөгөөд энд үүрлэдэг ба өндөр дов сондуултай газар дэгдээхийгээ нуудаг. Энэ нь зөвхөн байгалийн нөхцөлд үүсдэг бөгөөд малын бэлчээрлэлт энэхүү байдлыг хангаж чадахгүй.

Том мэрэгч амьтад болох талын тарвага (*Marmota bobak*), зурам (*Spermophilus sp.*) зэрэг нь магадгүй зэрлэг туруутан амьтдын бэлчээрлэлтэй холбоотой байж болох юм. Эдгээр мэрэгч амьтдын тоо толгойн бууралт нь махчин шувууд тухайлбал цагаан элэгт (*Circus macrourus*), талын сар (*Buteo rufinus*), тарважи бүргэдийн (*Aquila nipalensis*) тоо толгойд шууд нөлөө үзүүлнэ. Устан алга болж байгаа нөмрөг тас (*Aegypius monachus*), ухаа хажир (*Gyps fulvus*) тоо толгой нь буурсан бөхөнтэй холбоотой байж болох юм. Өвөл цас орсны дараа ихэнх мэрэгч амьтад ичдэг бөгөөд үүний улмаас чонын идэш тэжээл хомсдон бөхөнгийн сүргээс хамааралтай болно. Чоно гол төлөв сургийн хөгшин, эсвэл сүл дорийн амьтан барьдаг ба хэрэв тухайн амьтан эрүүл тохиолдолд чоно хөөж гүйцэхгүй бөгөөд бөхөнг барьж идэхэд хүндрэлтэй болно. Өнөө үед тулгараад буй махчин ба золис амьтдын тэнцвэргүй байдлын улмаас чоно тосгонд ойртон хонь болон бусад гэрийн малд довтолж байна. Энэ шалтгааны улмаас орон нутгийг иргэд чоныг их хэмжээгээр агнаж байна. ADCI тесөл нь их сургуулиуд болон судалгааны хүрээлэнгүйтэй холбоо тогтоох замаар тусгай хамгаалалттай газар нутгийг төлөвлөх, нүүдлийн замыг хамгаалахтай холбогдсон суурь мэдээллийг цуглуулахын тулд дараах ажлыг хийж байна.

- ADCI- нь одоогоор тал хээрийн сукцесс, экосистемийн нөхөн сэргэлтийн судалгааны төслийг Грейфсвoldын их сургууль, Казахстаны судалгааны хүрээлэнтэй хамтран боловсруулж байна
- Хавтгаалжийн экосистемийн хэрэгцээ, түүний гэрийн болон зэрлэг туруутан амьтадтай хэрхэн хамааралтайг RSPB болон ACBK төслүүд судалж байна
- Хүмүүсийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, газар ашиглалт, болон Бетпакдалагийн бөхөнгийн популяцийн демографын чиг хандлагын талаарх судалгааг ADCI тесөл хэрэгжүүлж байгаа бөгөөд уг судалгааны ажлыг Германы Техник Хамтын Ажиллагаа (GTZ) санхүүжүүлж байна



## ШИНЭ МЭДЭЭ



**ICCF** 2008 оны 6 сард Бөхөн Хамгаалах Холбооны гишүүд International Conservation Caucus Foundation"-сангийн шугамаар уригдан АНУ-ын Конгрессийн гишүүдэд бөхөн хамгааллын талаар илтгэл тавылаа. Доктор Алина Каал “Бөхөн Хамгаалах Холбоо”-г төлөөлөн оролцон ICCF-ын хүрээнд бөхөнгийн талаар илтгэл тавьсан бол WILD Сан-г төлөөлж Карен Роз Оканганго Делтагийн талаар илтгэл тавьсан.

### АНУ-ын Конгрессийн гишүүд бөхөнгийн тухай илүү ихийг мэдэж авлаа

Төв Ази болон ОХУ нь эрчим хүчиний тал дээр Америкийн гадаад бодлогод голлох байрыг эзэлдэг учир бөхөнгийн талаарх илтгэлийг өндөрөөр хулээн авсан.

*Илтгэлийн талаарх бичлэгийг узэхийг хүсвэл дараах хаягаар орно уу!*

<http://iccfoundation.us/e-briefings/20080613karenross/index.htm>.

### Байгаль хамгаалах хамтын ажиллагаа

Госкомприрода (Бүгд Найрамдах Узбекстан Улсын Байгаль Хамгаалах Зөвлөл) болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөө Аж Ахуйн Яамны харьяа Ой болон Амьтан Хамгаалах зөвлөлийн хамтарсан хурал 2008 оны 2 сард Ташкентад болж өнгөрлөө. Уг хурлын үеэр Устюртын бөхөнгийн популяцийг хамгаалах 2008-2010 оны үйл ажиллагааны хамтарсан төлөвлөгөөнд гарын үсэг зурлаа.

Уг хамтын ажиллагааны хүрээнд Узбекийн төлөөлөгчид Казахстан улсад 2 сард явуулсан бөхөнгийн агаарын тооллогод оролцлоо (доорхийн хар). Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Бүгд Найрамдах Узбекстан Улсын Госкомприродагийн Госбиоконтролын Геннадий Гончаровтой холбоо барина уу! [gosbiocontrol-ruz@sarcor.ru](mailto:gosbiocontrol-ruz@sarcor.ru).

### Бөхөнгийн хамтарсан судалгааг Казахстанд хийв

Бөхөнгийн агаарын тооллогыг 2008 оны 4-р сарын 14-нөөс 5-р сарын 4-нийг хүртэлх хугацаанд хийж дараах байгууллагууд хамтран оролцов. Үүнд: Казахстаны Амьтан Судлалын Хүрээлэн, Хөдөө Аж Ахуйн Яамны Ой болон Бэлчээрийн Хэлтэс, “Охотзоопром” Ангийн Нийгэмлэг, Ойн Аж Ахуйн орон нутгийн хэлтэс, Казахстаны Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах Нийгэмлэг, болон Бөхөнгийн Хамгаалах Холбооны Узбекстаны төлөөлөгчид оролцлоо. Судалгааны үр дүнд бөхөнгийн нөөцийг 61000 толгой гэж тогтоосон ба үүнээс Бетбекдалгийн популяци 32300, Устюргад 10400, Уралын популяци 18300 толгой гэж тус тус гаргажээ.

2007 оны судалгаатай харьцуулахад нийт бөхөнгийн тоо толгой 11.3% өссөн хэдий ч Устюртын бөхөнгийн популяцийн тоо буурсан дун гарчээ. Узбекистаны Устюртын бөхөнгийн популяци яагаад буурсан талаарх асуулт өнөөг хүртэл нээлттэй хэвээр байна. Магадгүй цаг агаарын нөхцлөөс шалтгаалан жилээс жилд тоо толгой нь хэлбэлзсэн байж болох юм. Иймээс энэхүү асуудлыг шийдвэхийн тулд хоёр улс бөхөнгийн агаарын тооллогыг нэгэн зэрэг явуулах шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Казахстаны Амьтан Судлалын Хүрээлэнгийн Юрий Грачевтай холбоо барина уу! [terio@nursat.kz](mailto:terio@nursat.kz).



Онгоцны далавчин доорх бөхөнгийн сүрэг.

Зургийг В.Тугалев



Охотзоопрам болон Амьтан судлалын хүрээлэнгийн хамтарсан баг Уралын популяцийн тархац нутгийг судлах үеэр. Зургийг Дмитри Головцов

### Соргог бөхөн Казахстан улсын Улаан Номонд бүртгэгдлээ

Узбекстаны Яам Хоорондын Зөвлөлүүдийн уулзалт “Улаан Ном”-ын талаар Ташкентад 2008 оны 3-р сарын 5-нд болж өнгөрсөн ба уг уулзалтын үеэр соргог бөхөнг үндэсний Улаан Номонд оруулах шийдвэрийг санал нэгтгэй гаргалаа. Бүгд Найрамдах Узбекстан Улсын Госкомприродагийн 39 тоот шийдвэрээр соргог бөхөнг 4-р сарын 21-нд Улаан Номонд эмзэг зүйл статустай оруулсан. Бөхөнгийн агналтыг Узбекистанд 1991 оноос хориглон тусгай хамгаалалттай зүйл амьтны жагсаалтад багтаасан.

Гэсэн хэдий ч энэхүү шийдвэр нь үр дүнтэй байсангүй. Узбекистан дахь бөхөнгийн популяцийн нүүдлийн болон үржлийн үеийн сүргийн тоо толгой эрс буурсан учир бөхөнгийн статусыг өөрчлөн Узбекистаны Улаан Номонд оруулсан. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Бүгд Найрамдах Узбекистан Улсын Госкомприродагийн Госбиоконтролын А.А. Григорянцтай холбоо барина уу! [gosbiocontrol-ruz@sarcor.ru](mailto:gosbiocontrol-ruz@sarcor.ru).



## Узбекистан дахь бөхөн хамгаалагчтай боллоо

Бөхөн хамгаалалд тулгараад буй асуудлыг яаралтай шийдэхийн тулд Узбекстаны Госкомприрода байгууллага Казахстан улсын Шүүхийн Зөвлөл хамтран 2008 оны 2-р сарын 15-нд SAI (Амударягийн Тусгай Хяналт)-ыг байгууллаа. Уг байгууллагын гол зорилго бол Амударя мөрөн орчмын амьттан болон ургамлын аймгийн төрөл зүйл тухайлбал Бухар буга, хар сүүлтий, тоодог болон бусад зүйл амьтныг хамгаалах, заг болон туранга (улиас) зэрэг мөддүүн хууль бус олборлолтыг таслан зогсоох явдал юм. Устюртын тэгш өндерлөг нь Хяналт шалгалт явуулах газар нутгийн нэг хэсэг нь юм. Хяналт шалгалтын баатарын зургаан хүний

бүрэлдэхүүнтэй ба УАЗ маркийн хоёр автомашинаар хяналтаа явуулдаг. Багийн хяналтыг өргөн уудам нутагт (Устюорт болон АраУал тэнгисийн зүүн эргэс Кизилорда мужийн хил хүртэлх 10 сая гаруй га газар нутаг) хийдэг ба гол төлөв бөхөнгийн хууль бус агналтыг хянадаг. Иймээс бөхөн хамгааллыг сайжруулахын тулд олон улсын байгууллага болон бусад эх үүсвэрүүдээс санхүүжилт олох нь туйлын зорилго юм. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл SAI-ийн Маскет Косбергеновтой холбоо барина уу!  
[erpronmakset@mail.ru](mailto:erpronmakset@mail.ru).

## **Хятадын засгийн газар бөхөнгийн гаралтай эмийн түүхий эдийн худалдааг таслан зогсоох шийдвэр гаргав**

Хятадын Ойн Аж Ахуйн Хэлтэс, Эрүүл Мэндийн Яам, Уйлдвэрлэл Худалдааны Хэлтэс, Хүнс болон Эмийн Хэлтэс, болон Хятадын Уламжлалт Анагаах Ухааны (ТСМ) Хэлтэс хамтран “Соргог бөхөн, панголин, болон зарим ховор могойн зүйлийн хамгааллыг сайжруулах, эдгээр амьтдын гаралтай эмийн түүхий эдийг зохицуулах менежментын тухай мэдэгдэл”-ийг 2007 оны 11-р сарын 12-нд гаргалаа. Панголин, зарим ховор могойн популяцийн огцом бууралт, мөн Хятадын зах зээл дэх бөхөнгийн эврийн хомсдлоос болж гаргасан уг мэдэгдлийн улмаас ТСМ-ийн эмийн нөөц хомсдох магадлалтай. Хятад руу хууль бус амьтны гаралтай түүхий эд гаргах явдал нь олон улсын байгууллагуудын санааг зовоож байна. Иймээс CITES болон IUCN нь соргог бөхөнг хамгаалах, хууль сахиулах үйл ажиллагаа болон хамгааллын менежментийг сайжруулах шийдвэрийг гаргасан.



# Хягдаан уламжлалт анагаах ухааны түүхий эдийн зах. Зургийг Ли Лишу

Бөхөнгийн эврийн худалдааг зогсоох менежментийн ажлын хурээнд дараах зорилтуудыг тавьжээ:

- 1) Бөхөн, панголин, болон ховор зүйлийн могойн зэрлэг популяцийг нөхөн сэргээхийн тулд гаршуулан үржүүлэх ажилд эдгээр амьтдын түүхий эдийг ашигладаг хэрэглэгчдийг татан оролцуулахад дэмжлэг үзүүлж удирдах
- 2) Хятадын зах зээл дэх амьтны гаралтай түүхий эдийг шалган буртгэж, жагсаалт гарган эдгээр түүхий эдийг хадгалах агуулахааудыг нэгэн ижил стандартад оруулах

3) Одооноос эхлэн тодорхой тооны цөөн эмнэлэгт ТСМ-ийн

эм үйлдвэрлэхэд зориулан бөхөнгийн эврийн хэрэглээг хязгаарлах. Ингэнсээр зөвшөөрөгдсөн эдгээр эмнэлгүүдээс бусад газарт бөхөнгийн эврийн худалдаа зогсоно. ТСМ-ийн эм бэлдмэл хийхэд бөхөнгийн эвэр шаардлагатай аливаа эмнэлэг нь Хүнс болон Эмийн Хэлтсээс зохих шаардлагатай зөвшөөрлийг авах ёстай.

4) Бөхөнгийн эврийн хууль бус нийлүүлэлтийг зогсоохын тулд зах зээл дээрх бүх түүхий эдийг бүртгэсний дараа тодорхой тооны зөвшөөрөл бүртгэлтэй эмнэлэгүүдэд эврийг худалдах ба эдгээр эмнэлэгүүд ТСМ-ын эм болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн.

5) Бөхөнгийн эвэр ашиглан үйлдвэрлэж буй ТСМ-ын бүтээгдэхүүнүүдэд шошго наана. 2008 оны 3-р сарын 1-нээс эхлэн бөхөнгийн эвэр ашиглан үйлдвэрлэж буй ТСМ-ын бүхий л бүтээгдэхүүнүүдэд “China Wild Animal Utilization and Business Operation Label” гэсэн шошго наах ба зах зээлд гаргахдаа худалдаж болох хамгийн бага хэмжээгэр савлана.

6) Хууль сахиулах ажиллагааг чангатгах хэрэгтэй төдийгүй бөхөнгийн эвэр хууль бусаар худалдсан тохиолдолд хатуу шийтгэх хэрэгтэй. Энэхүү шийдвэрийг гаргахын өмнө бөхөнгийн эврийг хэрэглээг цөөн хэдэн ТСМ-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эмнэлэг болон эм ханган нийлүүлдэг зарим компаниудын хүрээнд бүртгэн хянаж байсан. Мөн бөхөнгийн эврийн жижиглэнгийн худалдааг зохицуулах зохицуулалт байгаагүй. Энэхүү шинэ шийдвэр гарснаар дээрх зүйл амьтдын түүхий эд ялангуяа бөхөнгийн эврийн гар дээрх худалдааг хянан зохицуулах боломжтой болсон. Уг шийдвэр нь бөхөнгийн эврийн гар дээрх худалдааг зогсоох талаарх боломжит менежентийг сурталчлахад тустай.

## **Халимагийн сонинд бөхөнгийн тухай**

2008 оны 5-р сарын 23-нд “Известия Калмыкии” (Халимагийн мэдээ) сонинд “A demographic crisis” гарчигтай өгүүлэл нийтлэгдсэн бөгөөд энэ өгүүлэлд энэ жил соргог бөхөнгийн янзагалалт жирийн үеийнхээс оройтож 5-р сарын дундуур хүйтэн өдрүүдэд эхэлсэн талаар бичжээ. Шинээр мэндэлсэн янзаганы тоо өмнөх жилүүдийнхээс бага байгаа талаар дурдсан байна. Чёрные Земли Биосфер Улсын Нөөц Газрын судлаачдын үзэж буйгаар Тингутински (Степной) заказник болон Чёрные Земли хамгаалалттай газруудад ирж төллөсөн шаргагчны тоо өмнөх жилүүдийнхээс бага байгаатай холбоотой (2007 онд

12000 шаргагчин янзагалсан бол энэ жил 7000 орчим). Энэ нь цаг агаарын нөхцөл (өнгөрсөн жил ган болсон учраас бөхөн тухайн нутгийг орхиход хүрчээ) болон салбар хоорондын хамтын ажиллагаа дутагдалтайн улмаас үүдсэн (бөхөн хамгаалах менежментийн эрхийг Росселкознадзор доорх Холбооны агентлагаас орон нутгийн Байгаль Хамгаалах Яаманд шилжүүлэх ажил одоог хүргэлт үргэлжлилж байгаа) хамгаалалт сүл байгаагаас болсон гэдэгт мэргэжилтнүүд итгэж байна.



Гэсэн хэдий ч энэ жил цаг агаарын байдал тааламжтай байснаас хавар бороо их орж ургамлын гарц сайн байгаа нь бөхөнгийн

## Саратовын олон улсын сургуулийн семинарын үеэр залуу эрдэмтэд бөхөн хамгаалалд учраад буй тулгамдсан асуудлуудыг хэлэлцлээ

“Тал хээрийн экосистемийн байгалийн болон антропогенийн динамик, байгаль орчны өөрчлөлтийг хамгаалал арга замууд” сэдэвт олон улсын залуу эрдэмтдийн семинар Северцовын Нэрэмжит Экологи, Эволюцийн Хүрээлэнгийн (СНЭЭХ) Саратов дахь салбарт 2008 оны 3-р сарын 5-7-нд болж өнгөрлөө. Шилдэг эрдэмтэд залуу судлаачидад зориулан тал хээрийн судалгааны талаарх илтгэлүүдийг тавьсан төдийгүй аялалыг зохион байгуулсан. Залуу судлаачид тал хээрийн бүс, түүний экологийн бүлгэмдэл, хээрийн амьтны аймагт байгалийн болон хүний зүгээс үзүүлэх нөлөө, хээрийн экосистемийн хамгааллын асуудлуудын талаар илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. СНЭЭХ-г төгссөн судлаачид болох К.О. Ларионов, Н.Ю. Арылов нар Каспийн баруун хойд хэстийн заримдаг цөл, тал хээрийн туруутан амьтдын төлөөлөгч болох бөхөнгийн талаарх хоёр илтгэлийг тавьсан нь хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын анхаарлыг ихээр татжээ. Энэхүү семинарын үеэр хэлэлцүүлсэн илтгэлүүд нь “Поволжский Экологический Журнал” сэтгүүлийн тусгай дугаарт нийтлэгдсэн.

хувьд таатай нөхцлийг бүрдүүлж байгаа бөгөөд иймээс бөхөн өвс хайн дархан цаазтай газраас хол нүүх шаардлагагүй болж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хувсвэл Оросын Шинжлэх Ухааны Академийн СНЭЭХ-ийн Наталья Арыловатай холбоо барина уу! [arylova@gmail.com](mailto:arylova@gmail.com).



Оролцогчид олон улсын сургалтын үеэр  
Зургийг Елена Данзалова

## Хятад улсын Юннан хотод Бөхөнгийн эвэр хууль бусаар худалдаалсан

Канминг нисэх буудлын аюулгүйн хяналтын үеэр 2008 оны 1-р сарын 20-нд Зежианг мужийн иргэн хатагтай Лигийн тээшнээс хоёр ширхэг бөхөнгийн эвэр илэрсэн ба түүнийг саатуулсан байна. Ли хэлэхдээ тэрээр уг хоёр эврийг Канминг хотод байрлах Хятадын Анагаах Ухааны Эм (ХАУЭ) зардаг Жихуаюан зах дээрээс худалдаачин Зоугаас нийт 1800 руб (~225\$)-аар хадам ээжийнхээ эмчилгээнд зориулан худалдан авсан хэмээн мэдэгджээ. Уг мэдээллийн дагуу орон нутгийн цагдаагийн газар тухайн өдрийн орой ХАУЭ-ын Жихуаюан зах дээрх Зоугийн дэлгүүрт шалгالت хийхэд 28 бөхөнгийн эвэр илэрчээ. Зоу мэдүүлэхдээ уг эврүүдийг гурван жилийн өмнө ХАУЭ-ын зах дээрээс Шинжианы иргэдээс 30 эврийг кг-ийг нь 6800 руб (~850\$)-оор тооцон худалдан авсан хэмээн хэлжээ. Хятадын Шинжлэх Ухааны Академийн харьяа Канмингийн Амьтан Судлалын Хүрээлэнгийн шинжэчдийн дүгнэлтээр эдгээр 30 эврийн 22 нь бөхөнгийн эвэр болох нь тогтоогдсон бөгөөд бөхөн нь Хятадын Дархан Цаазтай Амьтдын 1-р зэрэглэлд багтдаг байна. Одоогоор уг хоёр сэжигтнийг эрүү үүсгэн шалгаж байна.



Захуудаас хураагдсан бөхөнгийн эвэр.  
Зургийг Зао Яао

## Хятад улсын Гансу мужид хууль бусаар худалдаалж байсан 6 бөхөнгийн эврийг хураан авлаа

Лангжуогийн Синхуа Нет-ийн 2008 оны 1-р сарын 16-ны дугаарт Гансу мужийн цагдаагийн газар хууль бусаар худалдаалж байсан амьтны гаралтай түүхий эдийг хураасан талаар олон улсын зэрлэг амьтан хамгаалах байгууллага мэдээлжээ.

Үүнд бөхөнгийн эвэр 6 ширхэг, үнэгний арьс 1, мөн зааны соёогоор хийсэн 90 бүтээгдэхүүнүүд багтаж байна. Энэ хэрэгт холбоотой 12 хүн хөргээ хүлээгээд байна.

## Халимагт бөхөн агнан ачиж явсан хулгайн анчныг

Халимагийн Яашкул дүүргийн Дотоод Явдлын хэлтсийн ажилтнууд 2008 оны 1-р сарын 8-нд ВАЗ 2107 маркийн машин хөлөглөн явсан Хулхуттагийн иргэн 43 настай М.В Романенког саатуулсан тухай

Парламентский Вестник Халмий (Халимагийн Парламентийн Хэвлэл) мэдээллээ. Романенко мотоцикл ашиглан бөхөн агнасан нь тогтоогдсон байна.



## Охотозоопромын байгаль хамгаалагчид Байканур сансрын бааз орчимд бөхөн агнаж байсан хүлгайн анчдыг барьж саатуулав

Кизилорда мужийн Каражусаны нутгаас хэд хэдэн бүлэг хүлгайн анчдыг 2008 оны 1-р сарын 17-нд барьж саатууллаа хэмээн Казахийн “Экспресс-К” соини сурвалжлагч Илия Гук мэдээллээ. Байцаагчид эхлээд ЗИЛ маркийн машиныг шалгах үед дөрвөн бөхөн, 12 калибрин хоёр ширхэг спорт загварын бууг илрүүлжээ. Дараа нь тэд гурван машиныг саатуулан шалгахад үед хоёр бөхөн,

мөн 12 калибрин спорт загварын буу хоёр ширхэг, 7.62-ын “Saiga” бууг нэгийг илрүүлсэн байна. Уг хэргүүдийг Кизилорда мужийн Дотоод Хэргийн Хэлтэст шилжүүлсэн байна. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар ороно уу!

[http://www.express-k.kz/show\\_article.php?art\\_id=14461](http://www.express-k.kz/show_article.php?art_id=14461)

## Бөхөнгийн тухай мэдээ

**Казахстан:** Төв Ази 2008.06.27 [Товчилсон хувилбар]

<http://www.centrasia.ru/newsA.php?st=1214553420>

### Сайга сага

**Хэн/юу Казахстанийн бөхөнгийн популяцийг хядсан бэ. Бөхөнгийн тоо толгой сүүлийн 15 жилийн дотор 1.3 саяас 60.000 болтлоо буурав.**

Шүүхийн системийн хүнлэг ёс соргог бөхөнгийн үхэл хорогдолд түүх, уур амьсгал, болон хөрш орныг буруутгаж байна. Энэ бол Алматад болсон байгаль дээр тоо толгой нь эрчимтэй хорогдож буй нэн ховор бөхөнгийн хамгаалал болон түүнийг гаршуулан уржуулэхэд чиглэгдсэн хэвлэлийн бага хурлын сэдэв байсан.

Казахстанд бөхөнгийн тоо толгой 1993 онд 1.300.000 хүрч байсан. Гэсэн хэдий ч 2003 он гэхэд зөвхөн 21.000 орчим бөхөн тоологдсон байна. Энэхүү тоо толгойн бууралтанд олон хүчин зүйл нөлөөлсөн ба 1993 оны зудны үеэр олон тооны бөхөн Узбекистан руу нүүр сэн. Эдгэрээр амьтад тухайн зудны үеэр айлын байшин руу орж ирсэн ба тэр үед нь хүмүүс тэдгээрийн дийлэнхийг агнасан байна. 1995 оноос хүний нөлөөнөөш шалтгаалсан сүүрэл газар авч эхэлсэн. Гэвч бөхөнгийн эврийг худалдаж эхэлснээр бөхөнг агнах явдал улсын хэмжээнд тэсрэлт болсон. Хулгайн анчид агнасан амьтныхаа зөвхөн эврийг нь авч маыхг хаядаг байсан байна. Үүний үр дүнд тал хээр бөхөнгийн сэг зэмэр дүүрсэн. Эдгэрээр бөхөнгийн эврүүд Хятад руу худалдаалгаж эхэлсэн. Дөнгөж 1999 оноос эхлэн хүнд сурталтууд бөхөнд учирч буй эмгэнэлт явдлын талаарх байгаль хамгаалагчдын дуу хоолойг сонсож эхэлсэн байна. Ингээд бөхөн агнальтыг хорих асуудал тавигдажээ. Одоогийн байдлаар нийт бөхөнгийн тоо толгой 61.000 орчим байна. Устьюртын бөхөнгийн популяцийн тоо толгойн бууралт өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Өнгөрсөн жилийн судалгаагаар Устьюртын бөхөнгийн тоо толгой 15.000 орчим байсан бол энэ жил ердөө 10.000 орчим л тоологдсон байна. Амьтан судлаачдын үзэж байгаагаар энэхүү тоо толгойн бууралт нь бөхөнгийн сүрэг өвлүүн улиралд Узбекистан болон Туркменистан улсууд нүүдэллэсэнтэй холбоотой гэж үзэж байгаа бөгөөд эдгэрээр газар нутгууд бүрэн хамгаалагдаагүй байна. Хөрш орнууд мөн энэ хүчин зүйлийг хүлээн зөвшөөрдөг.



Бетпакдалад бөхөн толлох үеэр.  
Зүргүйг Орчен Шаймуханбетов

Зэрлэг амьтан, усны нөөцийг тогтвортой ашиглах, тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулах 2008-2010 оны Улсын Хөтөлбөрийг энэ жилээс хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөр нь 2005-2007 онд хэрэгжүүлсэн хөтөлбөртэй ижил бөгөөд түүний үргэлжлэл юм. Ховор болон устаж буй амьтдын хамгаалалыг сайжруулахад шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг улсын хэмжээнд сайжруулж байна. Одоогийн байдлаар уг үйлчилгээнд зориулж 40 автомашин төсөвлөжээ. Тусгай мэдээллийг санг бий болгож анчдын хаваста хэргийн талаарх мэдээллийг үүнд бас агуулна. Үүнээс гадна Казахстанийн зэрлэг амьтныг хамгаалах, хулгайн анг хянах зорилготой Алтин Дала хэмээх байгаль орчныг хамгаалах урт хугацааны төсөл хэрэгжиж эхлээд байна. Зарим ТББ-ууд болох Казахстанийн Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах Холбоо, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) уг үйл ажиллагаанд нэгдээд байна. Үүнээс гадна ТББ тусгай хамгаалалттай бус нутгийг байгуулахад хамтран ажиллаж байна. Бөхөн хамгаалалтай холбоотой асуудлыг олон улсын түвшинд шийдвэрлэж 2007 оны 5-р сард Казахстан, Туркменистан улсууд бөхөн хамгаалах засгийн газар хоорондын хамтын гэрээнд гарын үсэг зурсан. Уг гэрээтэй төстэй гэрээг Узбекистан улстай байгуулахаар зохион байгуулалтын шатандаа явж байна. Одоогийн байдлаар хууль бус агуунур нь бөхөнгийн тоо толгойн бууралтанд нөлөөлөх гол хүчин зүйл болж 2007 онд 2500 гаруй хулгайн ангийн тохиолдол бүртгэгдсэн боловч зөвхөн 120 орчим хэргийг шүүхээр шийдвэрлэсэн. Шүүх системийн “хүнлэг” байдлаас шалтгаалан хулгайн ангийн ихэнх гэмт хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Ял хүлээлгэх нь хамгийн зөв шийтгэл юм. Автомашиныг хураан авах нь зүй зохистой. Амьтан судлаачид Хууль Зүй болон Дотоод Хэргийг Яамдыг татан оролцуулсан боловч ямар нэг үр дүнд хүрээгүй. Байгаль хамгаалагчид “хулгайн ан хийхэд оролцсон том оврын автомашинуудыг улсын орлого болгосноор хулгайн анг зогсоон” гэдэгт итгэлтэй байна. Хуулиар бол “машин ашиглан амьтанг хөөж эцээх нь хулгайн ан гэж үздэг” хэмээн тэд хэлдэг. Гэсэн хэдий ч үүнийг баглана гэдэг байгаль хамгаалагчдын хувьд бараг боломжгүй зүйл юм. Учир нь хулгайн анчдын үйлдлийг зөвхөн бичлэг хийж баталгаажуулсан үед л нотлох боломжтой. Сүүлийн үед хулгайн анчид дөрвөн дугуйт мотоцикл, цаснаа явагч ашиглан ан хийх болсон байсан. Тэдний ашиглаж буй машин техник хулгайн анчдынхаас харьцангуй муу хэмээн хяналтын байцаагчид олон удаа гомдол мэдүүлсэн. Үүнээс гадна чинээлэг хүмүүс байнга ан хийдэг учраас зарим тохиолдолд торгууль явахад хүндэрлэж учирдаг байна. Ийм учраас торгуулийг чангатган, бүхий л зиндааны хүмүүст адил тэгш ноогдуулах хэрэгтэй гэж амьтан судлаачид үзэж байна.

Алина Бекирова

## Мэдээлэл

Бөхөн агнасан тохиолдолд ойролцоогоор 150.000-200.000 тенгэгийн тогтууль ноогдуулна. Хэрэв бөхөн агнасан нь батлагдвал турван жил хүртэлх хугацаагаар хориход хангалттай шалтгаан болно. Казахстаны засгийн газрын 2004 оны 1-р сарын 8-ны өдрийн 18-р хуулиар турруутан амьтдын хээлтэй шаргагчинг агнасан тохиолдолд торгох тогтуулийн хэмжээг тогтоосон. Уг хуулиар бөхөнгийн шаргагчин юмуу янзага агнасан тохиолдолд 70.000 тенгегээр торгоно.

## ΘГҮҮЛЛҮҮД

## **Казахстаны бөхөн хамгаалал**

<sup>1</sup>Б.З. Дуйсекеев, <sup>2</sup>С.Л. Скляренко

<sup>1</sup> Казахстан улсын Астанагийн Хөдөө Аж Ахуйн Яамны

## *ОАА болон Бэлчээрийн Хороо*

<sup>2</sup> Казахстаны Биологийн Олон Яңз Байдлыг

Бөхөнгийн тоо толгой огцом буурсны улмаас уг амьтныг хамгаалах явдал үндэсний асуудал болоод байна. Казахстан улсад одоогийн байдлаар бөхөнгийн турван популяции тухайлбал Бетпакдаа, Устюрт, болон Уралын оршиж байгаа бөгөөд эдгээр нь нийт 10 засаг захирагааны нэгжид хуваагдана. Үүнд: Актюбинск, Атирау, Замбыл, Баруун Казахстан, Караганда, Кызылорда, Мангистау, Өмнөд Казахстан, болон Акмола ба Алматагийн зарим хэсэг багтана. Бөхөнгийн популяцийн тоо толгойн огцом бууралтын үндсэн шалтгаан нь бөхөнг нийт тархац нутагт нь жилийн турш хулгайгаар агнасантай холбоотой. Казахстан улсын засгийн газар бөхөнг устаж алга болохос өмнө янз бүрийн арга хэмжээг үндсний хэмжээнд авч байна. 2001 он бол эргэлтийн гол үе байсан бөгөөд бөхөнгийн популяцийн мониторинг болон хамгаалалд зориулан улсын төсвөөс 14 сая тенге хуваарилсан. Дараа дараагийн жилүүдэд уг төсвийн хэмжээ байнга нэмэгдэж ирсэн. Хөдөө Аж Ахуйн Яамны Ойн Аж Ахуй болон Бэлчээрийн хороо, Амьтан Судлалын Хүрээлэн хамтран “Ховор болон нэн ховор туруутган болон соргог бөхөнг хамгаалах 2005-2007 оны хотолбор”-ийг боловсруулсан. 2005 оны 3-р сарын засгийн газрын захирамжаа уг хотолбөрийг орон нутгийн засгийн газартай хамтран мушкин хэмжээнд хэрэгжүүлжээ. Тухайн жил 182.5 сая тэнгэг уг хотолбөрийн хэрэгжилтэнд зориуулж төсөвлөсөн. 2006 онд уг төсвийн хэмжээ 205 сая тэнгэг хүрсэн төдийгүй мөн 2007 онд энэ төсөв 200 саяас (1,000,000 ам.доллар) илүү гарсан байна. Казахстан улс Эрүүгийн Гэмт Хэргийн тухай хууль болон Хэрэг Зөрчлийн заалтандaa өөрчлөлт оруулсан төдийгүй хуулиар хориглосон амьтны гаралтай бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авсан тохиолдолд тортгууль ноогдуулах болсон ба ингэснээр бөхөнгийн хууль бус агууруын эсрэг авч буй арга хэмжээг бэхжүүлэх ач тустай болжээ. Амьтны гаралтай хориотой түүхий эдийг хэн нэгэн танихгүй хүнээс худалдан авсан тохиолдолд цааш нь мэдэгдсэнээр хулгайн анчид ял шийтгэлээс мултрах боломжгүй юм. 2005 оны 9-р сарын 22-нд гаргасан Зөвлөлийн 206 тоот шийдвэрээр шинжлэх ухааны зориулалтаас бусад тохиолдолд бөхөн агнах, бөхөнгийн эвэр болон бусад эд эрхтнийг цуглуулах, хадгалах, худалдах, худалдан авахыг Бүгд Найрамдах Казахстан улсын хэмжээнд 2011 он хүртэл хорьсон. Уг шийдвэрийг Бүгд Найрамдах Казахстан Улсын Хууль Зүйн Яаманд бүртгэн авсан. Уг хотолбөрийн хүрээнд бөхөнгийн популяцийг жилд 10%-аар өсгөхийн тулд хамгааллын арга хэмжээг идэвхитэй хэрэгжүүлэх ажлууд хийгдэж байгаа ба үүний үр дунд бөхөнгийн тоо толгой үйлдвэрлэлтийн зориулалтаар агнах хэмжээнд хүрнэ. Бөхөнгийн өнөөгийн тархац нутгийг тогтоосон ба тоо толгойг хязгаарлагч хүчин зүйлсийг (хулгайн ан, чоно) арилгах ажлууд хийгдсэн. 2005-2007 онуудад бөхөнгийн бүх тархац нутгийн хэмжээнд зохион байгуулалттай ангийн отог гарган нийт 5000 чоно агнасан. Бөхөн олноор байршдаг газруудад хамгааллын ажлыг “Охотозоопром” хийж гүйцэтгэсэн. Нийт 83 хяналтын байцаагчаас бүрдсэн 9 хөдөлгөөнт эргүүлийн баг 3 автомашин болон 4 уралдааны мотоцикл ашиглан ээлжлэн хяналтын ажлыг гүйцэтгэж байна.

Зөвлөлийн орон нутгийн хэлтэс болон хууль сахиулах байгууллагуудыг мөн бөхөн хамгаалалт татан оролцуулсан. Бөхөн хамгаалах хөдлөгтөөнт эргүүлүүд галт зэвсэг, сансрэйн холбоо, камер, зургийн аппарат, хөдлөгтөөнт холбоогоор бүрэн тоноглогдсон. Тэр ч бүү хэл “Охотозоопром”-нь МИ-2 нисдэг тэрэг худалдан авсан ба үүнийг одоогоор бөхөн хамгаалалт ашиглаж байна. 2005-2007 онуудад Зөвлөлийн орон нутгийн хэлтсийн улсын байцаагчид, хууль сахиулагчид, “Охотозоопром”-ын ажилчид нийт 34 хулгайн анг илрүүлсэн ба эдгээр хулгайн анчид хууль бусаар нийт 210 бөхөн агнажээ. Эдгээр хулгайн ангийн хэргүүдийг шүүхэд шилжүүлэн зохих арга хэмжээнүүдийг авсан. Учруулсан хохиролынхоо төлөө эдгээр хулгайн анчид нөхөн төлбөр төлөх шаардлагатай байгаа юм.



**Охотзоопромын судлаачид Босой тосгоны ойролцох агаарын станцад Устюргын популяцийн тархцыг судлаж байхад.**  
**2008 он 30-р сарын 24-ны өдөр**

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд мөн бөхөн хамгааллын тухай кинонуудыг хийн олон нийтэд сурталчилжээ. Эдгээр кинонуудыг Казахстаны үндэсний телевизээр (Казахстаны Е1-Арна болон 31-р суваг) үзүүлэв. Уг кинонд бөхөнгийн тоо толгой өсөхийн хирээр хулгайн ан ихсэх боломжтойг дурдсан. Үндэсний олон нийтийн хэвлэл мэдээллийн тусламжтай орон нутгийн иргэд бөхөн хамгаалац болон уг амьтны тоо толгой нөхөн сэргээхийн тулд хийгдэж буй ажлууд мөн харгис, хөрцгий хулгайн ангийн талаар мэдээлэлтэй болж байна. Бөхөнгийн хулгайн ангийн баримтуудыг олон нийтийн хэвлэл мэдээллээр цацсанаар хулгайн анчдын эсрэг чиглэсэн орон нутгийн иргэдийн сорөг хандлагыг бий болгоход хувь нэмэр оруулах юм. Олон улсын төслийн нэг хэсэг болох “Казахстаны тал хээрийн гайхамшиг” сурталчилганы гарын авлагыг хэвлүүлэн сургуулийн хүүхдүүдэд тараасан (дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл “Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийг 4-р дугаарыг харна уу!). 2005 онд популяцийн тоо толгойн нөхөн сэргээлт, хамгааллын талаарх цуврал өгүүллүүдийг “Казакстанская правда” сонингийн “Бөхөнг хамгаал” бууланд нийтлүүлсэн.



“Охотозоопром” болон “Сеймар Нийгмийн Сан” хэмээх хувийн тусламжийн байгууллагатай хамтран бөхөнгийн тухай “Мөнхийн нүүдэлчдийг мөрдөхүй” хэмээх киног бүтээсэн. Орон нутгийн болон олон улсын байгаль хамгаалах байгууллагуудтай хамтран “Бөхөнгийн тууль” хэмээх нэртэй хүүхэлдэйн киног Казах, Орос, Англи хэл дээр гаргасан. Казахстаны Хөдөө Аж Ахуйн Яам, Охотозоопром, Бөхөн Хамгаалах Холбооны зөвлөл хамтран бөхөн хамгаалах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Казахстан, Хабар, Астана телевизийн сэтгүүлч, зураглаачидын багийг Бетпакдела дахь бөхөнгийн популяцийг хамгаалах чиглэгдсэн эргүүл хяналтын поstuudтай танилцах аялал 2007 оны 7-р сарын 27-29-нд зохион байгуулав. Сэтгүүлчидэд Кустанай, Актиубинск болон Караганда мужуудын хил орчмын газраар АН-2 онгоцоор нисэх боломж олдсон. Зураглаачид бөхөнгийн бичлэгийг агаараас хийсэн ба харин сэтгүүлчид Актиубинск мужийн орон нутгийн Зөвлөлийн гишүүд болон Охотозоопромын хяналтын байцаагчдаас ярилцлага авсан. Энэхүү алалын материалуудыг телевизээр гаргахаар бэлдээд байна. Бид мөн төрийн бус байгууллагуудыг бөхөн хамгаалалд татан оролцуулж байна. “SOS Saiga” төслийн хүрээнд “Сеймар Нийгмийн Сан” дөрвөн ширхэг ачааны КАМАЗ машин, арван УАЗ маркийн машин, радио, гар утас, GPS, шөнийн дуран зэргийг худалдан авч өгсөн юм. “Ак Бокен” олон нийтийн сан бөхөн хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхд мөн хамтран ажилласан билээ. Бөхөнгийн эврийн хил дамнасан хууль бус худалдааг зогсоохын тулд зөвлөл хил, гаалийн ажилчидтай харилцаа холбоогоо сайжруулж байна. Эдгээр цогц арга хэмжээнүүдийн үр дүн илэрхий мэдэгдэж байгаа бөгөөд энэ нь улсын төсвөөс санхүүжигддэг жил бүрийн мониторинг судалгаанаас харагдаж байна. Бөхөнгийн тооллогыг 2003 оны 4-р сарын 9-нд зөвлөлийн 82 тоот шийдвэрээр батлагдаж, Казахстаны бөхөнг агаараас тоолох арга зүйн дагуу турван популяцид бүгдэнд нь хийж гүйцэтгэсэн. Казахстаны Амьтан Судлалын Хүрээлэнгийн эрдэмтэд, Охотозоопром, орон нутгийн холбогдох хүмүүс уг тооллогод оролцлоо. Удирдах Төв Зөвлөлийн мэргэжилтнүүд эдгээр арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж байна. Охотозоопром болон Амьтан Судлалын Хүрээлэнгийн тайлангийн үр дүн болох бөхөнгийн тоо толгой 2003-2007 оны өөрчлөлтийг хүснэгтэд үзүүлэв. Зөвлөлийн идэвхитэй үйл ажиллагааны үр дүнд бөхөнгийн тоо толгой тогтвортой ёсөж буй үр дүн гарсан. Харин Устьюртын бөхөнгийн популяци буурч 1400 тоо толгойд хүрсэн байна (2006 онтой харьцуулахад 7.7%-аар буурсан). Учир нь Устьюртын бөхөнгийн популяци Казахстанаас Каракалпакстан (Узбекстан) руу нүүдэллэдэг цорын ганц популяци бөгөөд энэ нь жилийн турш хамгааллын арга хэмжээг авахад саад болж байна. Энэхүү нөхцөл байдал нь бөхөн хамгаалахад олон улсын хамтын ажиллагаа шаардлагатайг харуулж байна. Зөвлөл болон Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) хамтран 2004 онд хэлэлцүүлэг зохион байгуулан бөхөн хамгаалах “Хамтын ажиллагаа”-ны гэрээнд гарын үсэг зурлаа.

Казахстан улсын бөхөн хамгаалах байгууллага болон CMS-ын хэрэг эрхлэх газар хамтран бөхөн тархсан улс орнуудыг оролцуулсан олон улсын хурлыг 2006 оны 9-р сард Алматад зохион байгуулсан ба энэхүү хурал нь “Соргог Бөхөнгийн Хамгаалал, Менежмент”-ын тухай Харилцан Ойлголцлын Санамж Бичиг (ХОСБ) хэрэгжүүлэхд чиглэгдсэн. Бөхөн тархсан улс орнууд буюу Орос, Узбекстан, Туркменистан, Хятад, Монголын төлөөлөгчид мөн олон улсын байгууллагуудын төлөөлөгчид уг хуралд оролцсон. Энэхүү хурлын үеэр Казахстан улс ХОСБ-т гарын үсэг зурлаа. Казахстан, ОХУ, Узбекстан, Туркменистан улсууд ХОСБ-ийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд хамтын ажиллагааны хоёр талт гэрээ байгуулах шаардлагатай юм. Бүгд Найрамдах Казахстан улсын Хөдөө Аж Ахуйн Яам дээрхитэй төстэй гэрээг 2007 оны 5-р сард Туркменистан улсын засгийн газартай байгуулсан. Узбекистан улс руу хил дамнан нүүдэллэдэг Устьюртын бөхөнгийн популяцийг хамгаалах асуудал хамгийн том саад бэрхшээл ба үүнийг шийдэхийн тулд хамтарсан судалгаа болон хамгаалал шаардлагатай. Энэ зорилгын үүднээс засгийн газар хоорондын гэрээний нооргийг Зөвлөл бэлтгэсэн бөгөөд үүнтэй төстэй Уралын бөхөнгийн популяцийг хамгаалах гэрээг ОХУ-тай байгуулахаар бэлдээд байна. Эдгээр материалыудыг Орос болон Узбекийн талуудад танилцуулсан ба 2008 онд гарын үсэг зурна хэмэн найдаж байна.



**Бетбакдалад төрсөн нялх янзага, 2008 оны хавар.**  
Зүргийг Орчен Шаймуханбетов

Дараах зүйлүүдийг энэхүү гэрээнд тусгасан. Үүнд:

- бөхөн түүний амьдрах орчинг хамгаалах арга хэмжээг нэн даруй боловсруулан хэрэгжүүлэх
- бөхөнгийн популяцийн тооллогыг зохион байгуулах
- бөхөнгийн эд эрхтний худалдаа, ашиглалт, хамгаалалтай холбоотой хууль эрх зүйн асуудлыг зохицуулах
- бөхөнгийн агнуур, хамгаалалтай холбоотой мэдээллийг солилцох үүднээс бүх сонирхогч талуудыг оролцуулсан олон улсын хурал зохион байгуулах

#### Хүснэгт. 2003 – 2007 онд популяц тус бүр дэх бөхөнгийн тоо толгой (мянгаар)

Популяци	2003	2004	2005	2006	2007
Бетпакдала	1.8	6.9	9.9	18.6	22.8
Устьюрт	12.8	15.0	19.6	17.8	16.4
Урал	6.5	8.8	10.1	12.9	15.6
Нийт	21.2	30.7	39.6	49.3	54.8



Бөхөн хамгааллыг идэвхижүүлэн, нүүдлийн замыг нь хамгаалахын тулд Актюбинск, Кизилорда болон баруун Казахстаны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөхөөр төлөвлөж байна. Бүгд Найрамдах Казахстан улсын засгийн газрын 2007 оны 2-р сарын 14-ны өдрийн 109 тоот тушаалаар нийт 66 байгаль орчны хяналтын байцаагчдын бүрэлдэхүүнтэй Иргиз-Тугайн байгалийн нөөц газрыг байгуулсан. Бөхөн, түүний амьдрах орчин болох тал хээрийг хамгаалахын тулд Бүгд Найрамдах Казахстан улсын Биологийн Олон Янз Байдлыг Хамгаалах Холбоо (ACBK), Франкфуртын Амьтан Судлалын Нийгэмлэг (FZS), Шувуу Хамгаалах Вангийн Нийгэмлэг (RSPB), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), хамтран Алтин-Дала хэмээх том хэмжээний төслийг эхлүүлээд байна. Бетпекпала дахь бөхөнгийн тархац нутагт янз бурийн статустай Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Сүлжээг байгуулах, бөхөн хамгаалах үр дүнтэй арга боловсруулах, орон нутгийн иргэдтэй идэвхитэй хамтран ажиллах, болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэхэд засгийн газар, үндэсний болон олон улсын байгууллагуудыг өргөн хүрээтэй татан оролцуулахаар төлөвлөөд байна. Алтин-Дала санаачлагын хүрээнд 2007 оны 4-р сарын 26-28-нд ACBK бөхөнгийн тооллогыг агаараас хийх арга зүйн талаарх семинарыг зохион байгуулсан. Уг семинаарт FZS-ээс доктор М.Нортон-Гриффин, А.Ж. МкКонвелл, Зөвлөлийн орлогч дарга

Х.Ш. Мусааев, Охотозоопромын төлөөлөгчид, Амьтан Судлалын Хүрээлэн, ACBK, болон Зөвлөлийн орон нутгийн мэргэжилтнүүд оролцсон. Семинарын үр дүнд Казахстаны бөхөнгийн нөөцийн үнэлгээг нарийвчлал өндөртэй тогтоохын тулд одоо ашиглагдаж буй арга зүйг сайжруулах зөвлөмжүүдийг боловсруулсан. Бүгд Найрамдах Казахстан улсын засгийн газрын 2007 оны 10-р сарын 8-ны өдрийн 914 тоот тушаалаар “Зэрлэг амьтан, усны нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг байгуулах 2010 хүртэлх хөтөлбөр”-ийг баталсан нь бөхөнгийн тоо толгойг нөхөн сэргээх, хамгаалах ажлын үргэлжлэл юм. Костанай мужийн өмнө хэсэгт 489.000 га талбай бүхий Алтин-Дала байгалийн нөөц газрыг шинээр байгуулахаар төлөвлөж байгаа нь мөн энэ хөтөлбөрийн нэг хэсэг юм. Иймээс Казахстаны засгийн газар Зөвлөлөөр дамжуулан бөхөнгийн популяцийг нөхөн сэргээх, хамгаалах, мониторинг судалгааг явуулах, санхүүжилт олох тал дээр чадах бүхнээ хийж байна. Казахстаны болон олон улсын байгууллагуудыг бөхөн хамгаалахад өргөн хүрээтэй татан оролцуулж ажилснаар бөхөн тоо толгой тогтвортжсон төдийгүй өсөх хандлагатай байна. Бөхөн Хамгаалах Зөвлө болон Казахстаны ACBK байгууллага энэхүү зүйл амьтныг хамгаалахад хамтран ажиллах сонирхолтой аливаа байгууллагуудтай хамтран ажиллахад бэлэн байна.

## Бөхөн өсгөн үржүүлэх төв-Экологийн боловсролын төв

### Виктор Федосов

Халимагийн Зэрлэг амьтан хамгаалах төв, [kalmsaiga@elista.ru](mailto:kalmsaiga@elista.ru)

Агь шарилжны гашуун үнэр, болжморын жиргэх дуу, зурамны исгэрээ, хөх тэнгэрт өндөрт нисэж буй хээрийн бүргэд, өрөөсний сүргүүд, өвөгт тогорууны хосын үүр. Хээрийн энэ гайхамшигт зүйлүүдэд жаахан ч гэсэн сэтгэл хөдлөхгүй байхын аргагүй юм. Энэхүү хээрийн экосистемийн бүх зүйл харилцаан хамааралтай бөгөөд тэнд илүү их юмуу дутуу зүйл үгүй. Ийм учраас Халимагийн Бүгд Найрамдах улсын Зэрлэг амьтдыг хамгаалах төвийн (энэ нь Том өвсөн тэжээлт амьтдын сангаас (LHF) олон жилийн турш, мөн 2008 онд Руффордын жижиг тэтгэлгийн сангаас дэмжлэг авсан) үйл ажиллагаа зөвхөн бөхөн хамгаалахад хязгаарлагдаггүй болохыг илтгэнэ.

Энэ нь хээрийн ландшафтын амьдралын олон янз байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой юм. Тус төв экологийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр энэ зорилт руу чиглэжээ. Яшкилийн үржүүлгийн төв рүү хийх байнгын аялал үүний үр дүнг илтгэнэ.

Бөхөн үржүүлгийн төв нь хот болон төв замаас хол зайдтай атал маш их алдаршсан. Сургуулийн хүүхдүүд, энгийн хүмүүс, эрдэм шинжилгээний ажилчид гэх мэт 120 гаруй хүн энэ нөөц газарт жил бүр айлчилдаг. Тэд бөхөнгийн сүргийг илүүтэй сонирхдог байна. Амьтдыг үргэхээс урьдчилан сэргийлж, тусгайлан тоноглосон цамхагаас ажиглалт хийдэг. Эдгээр ажиглалтууд нь бөхөнг хойч үедээ үлдээх хариуцлагыг ухамсарлуулдаг. Мэдээгүй, хараагүй зүйлээ хайрлах, халамжлах боломжгүй юм.



Яшкилийн үржүүлгийн төв дэхь Халимагийн сургуулийн хүүхдүүдийн аялал

Зургийг Юрий Арылов



Бөхөн үржүүлэх төв рүү хийх аялал хөтөчийн ярьж буй түүхтэй уялдана. “Миний тухай бүх зүйлийг та нар мэдэх үү?” болон “Бөхөн хамгаалал-бидний амьдарч буй өв” гарчигласан товхимол, үзүүлэн зочдод хүрэлцээтэй. Эко аялал жуулчлал шинэ үзэсгэлэнг шаардлагагүй. Иймд Яшкулийн үржүүлгийн төвд хэдэн шинэ амьтад байдаг. Хоёр жилийн өмнө 3 залуу зэрлэг гахайг Төвд бэлэглэжээ. Тэд өсөж томрон одоо гахайн бүл үр удмаа хулээж байна. Хээлтэй эмэгчинд шаардлагатай байсан шинэ хашааг барьж байна. Үнээ бас хээлтэй байна. Өнгөрсөн жил ботго төрж байсан бөгөөд одоо дервөн тэмээтэй жижиг сүрэг хээрт хэрэн хэсэж явна. Эхэндээ амьтад төрж өссөн ферм руугээ буцахыг оролддог байсан ч баярлууштай нь ажилчдын хайр халамжаар тэд өөрсдийнхөө шинэ гэрт алгуурханаар дасаж эхэлж байна. Тэмээнүүд хол явдаггүй, махчдаас өөрсдийгөө хамгаалах

чадвартай учраас хэдийгээр тэмээ хээр хоносон ч гэсэн фермийн ажилчид санаа зовох зүйлгүй байдаг. Одоогийн байдлаар уужимхан үүрнүүдийг шувуудад зориулан барьж байна. Гурван тэмээн хяруул ирсэн байна. Тус төв шувуудын бусад зүйлүүдийг ч үржүүлэхээр төлөвлөжээ. Шархадсан болон өвдсөн амьтад үзүүлэх эмнэлгийн тусламжийг ч бас төлөвлөжээ. Тэгэхээр бөхөн үржүүлгийн төв экологийн боловсрол олгох газар болон өөрчлөгдөж, үхэр, шувуудын уламжлалт бус үүлдэр үржүүлж байна. Эдгээр үйл ажиллагаа нь хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх, үүнээс уламжлаад хулгайн антai тэмцэхэд хүчтэй хувь нэмэр оруулж чадах юм. Зэрлэг амьтад зохиомол нөхцөлд үржих бөгөөд хэзээ нэгэн цагт тэдгээр амьтдыг байгальд нь буцаан тавих сайхан боломж олдоно гэдэгт бид итгэлтэй байна.

## Узбекистаны Арап тэнгисийн зүүн эрэг дэх бөхөнгийн популяцийн хамгаалал

Косбергенов Максет

Узбекистаны Бугд Найрамдах улсын Байгаль Хамгаалах Үндэсний Хорооны Амударъяа  
мөрний мэргэжлийн хяналтын алба

-35<sup>0</sup> С-ээс доош буурсан температуртай ер бусын хүйтэн өвөл болсон учраас энэ жил хулгайн анчид бөхөн гөрөөсийг агнахад хүнд байлаа. Дээр үеэс хулгайн анчид бөхөнг үржлийн үед нь агнадагтүй ч намар таргалсан үед нь агнадаг байжээ. Гэвч одоогийн байдлаар махны үнэ өрөнхийдөө өссөнийн улмаас үржлийн үеийг оролцуулан ямар ч үед агнуур газар авсаар байна. Бөхөн янзгалах үедээ хэсэгхэн газарт бөөгнөрдөг бөгөөд тэд маш эмзэг болдог учраас хялбархан олз болдог. Хулгайн анчид янзагыг нь амьдаар барьж, түүнийг зардаг ба агнасан бөхөнгийн махыг давслан хадгалдаг байна. Хилийн 2 талаар байх чинээлг хүмүүс бөхөнгийн янзагыг амьдаар нь захиалж нэг хосыг 200 ам доллараар үнэлэн авдаг тул хэрэгцээ жилээс жилд өссөөр байна. Казахстаны Кызыл-Орда мужийн хил дагуу, Узбекистаны Мумак, Тахтакупир районд бөхөнгийн жижиг сүрэг (2004 онд 1000 орчим) бий. Эдгээр районууд нь ойролцоо хүн ам сууршсан газраас хол бөгөөд тэнд газрын тос болон хий олборлодогтүй, үнэндээ зэлүүд газар юм. Иймэрхүү газар бөхөн байх дараах тайлбар байж болох юм. Нэгдүгээрт: бөхөнгийн сүрэг Кызыл-Ордагоос ирсэн. Гэсэн хэдий ч тэр мужийн хүн ам ният сууршсан газраар дамжин ирсэн гэдэг нь үнэмшил багатай юм. Хоёрдахь боломжтой тайлбар нь Арап тэнгисийн Возрождение арлаас ирсэн байх магадлалтай. Хамгийн тохиромжтой тайлбар нь хүйтэн жижүүн салхинаас зугтган Устюртаас доошлон ирж бетонон худгийн ус агуулах сав, орхигдсон хийн хоолойнууд зэрэг хоргodoо газарт нуугддаг бөгөөд бид энд олон тооны хэвтэр, хөлдөж үхсэн болгалиудыг олсон. Заган шутуй нь салхинаас хоргodoо сайн нуувч, тэжээл болдог учраас бөхөн байрших таатай нөхцөл болдог. Арап тэнгисийн зүүн эрэг дэхь доворхог элснүүд нь

эдгээр амьтдын үндсэн амьдрах орчин биш боловч бөхөнгийн сүрэг тэнд жил болгон үржиж байна. Энэ нь сүрэгт хичээн тооны бөхөн байгааг мэдэх ач холбогдолтой юм. Бөхөн яж энэ ердийн бус нутагт амьд үлдэж байна вэ? Үндээн шалтгаан нь үндны усны хангалттай байдал (Кокдарьяа голын үер г.м.), хүн ам суурьшсан газраас алслагдсан (хамгийн ойрхон тостон 150-200 км зайдай), өвлийн улиралд хоргodoо газар хангалттай, машин зам бага байдаг зэрэг юм. Энэ бус нутгийн бөхөн агууруын онцлог бол янзага болон тэдгээрийн гулуузыг цуглуулдаг анчид нь төрөл бүрийн авто тээврийн хэрэгслээр аялан хийж байгаа нь тэдгээрийн гэмт хэргийн шинж чанартайг нотлох зүйлийг боломжгүй болгож байгаа юм. Гэсэн хэдий ч энэ нь бөхөн агнах хулгайн анчдын сүлжээ нь гэмт хэргийн шинжтэй, ашигтай, ямар ч шийтгэл хүлээдэгтүй бизнес болохыг гэрчилж байна. Тохтакупир мужийн бөхөн үржиж байгаа нутагт Амударьяа-н мэргэшсэн байгаль хамгаалагчид 2007 оны 5-р сард хийсэн хоёр шалгалтын нэгд нь хоёр машинтай, буутай долоон хүнийг саатуулан торгосон байна. Хэдий тийм ч гулууз мах, янзага тээвэрлэсэн, зөөврийн холбоогоор тоноглогдсон гурван ачааны машин мөрдөлтөөс амжилттай бултан Казахстан хөрш зэргэлдээ бус нутаг руу гарсан учраас, энэ нь бөхөнгийн хулгайн анд шууд холбоотойг нотлох боломжгүй байсан. Казахстанд ойрын хамаатан садантай, нутгаа сайн мэддэг хулгайн анчид мөшгөлтөөс амархан мултран гарч, дараа нь эргэн ирдэг байна. Гэвч хулгайн анчидтай хийх дайн зарлагдсан ба бөхенд хамааралтай хууль тогтоомж нь түүнийг амар олз болгох сонирхолтой хэнд ч өршөөл үзүүлэхгүй.

## Европын бөхөнгийн популяци дахь альбинизм

Манджиев Х.В., Мойсейкино Л.Г

Халимагийн Улсын Их Сургууль, [kalmsaiga@elista.ru](mailto:kalmsaiga@elista.ru)

Альбинизм бусад амьтдын олонхид нь байдаг шиг бөхөнд бас ажиглагддаг. Энэ нь меланины бүтээгдэхүүний хомсдлын үр дун юм. Меланин нь нарны цацрагийг илүүтэй шингээдэг

ба арьсыг хэт улаан түяанаас хамгаалах шүүлтүүрийн үүрэгтэй бөгөөд харах, сонсоход хамрагдах эрхтнүүдийн хэвийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой юм.



Албино амьтдын ер бусын байдал нь олон тооны домог, үлгэрийн эхлэл болжээ. Эрт цагт Калмык хүмүүс хээр талын эзэн Цагаан хөгшин хүн цагаан бөхөнд хувирэн ирнэ гэдэгт итгэдэг байжээ. Хэрвээ тэр гөрөөсийг алвал анчинд гай гамшиг нүүрлэнэ. Харин уг домог жинхэнэ бодит үнэн дээр суурилбал энэ нь цагаан өнгөтэй эсвэл хэсэгчилсэн цагаан өнгөтэй албино амьтан байж таарна. Бүх албино амьтдын амьдралын чадавхит маш муу ба эволюцийн явцад тэд “өршөөлгүйгээр” гологдон байгальд устгагддаг. Хэдий тийм ч цөөн тооны албино амьтад үр удмаа гаргах, амьд үлдэх чадвартай байна.



Х.Маджиев “хэвийн” болон албино бөхөнгийн янзагыг барьж байгаа нь  
Зургийг Юрий Арилов

Бөхөнгийн янзаганы дунд анхаарал татсан, оньсого мэт цагаан албино амьтад махчдын анхаарлыг татдаг. Иймэрхүү үзэгдэл нь орооны үед бас чухал ач холбогдолтой. “Цайвар”

албино эрэгчин амьтад эрэгчиний хүчтэй өнгийг давууд үздэг эмэгчнийг өөртөө татахад хэцүү байдаг. Ном зохиолд тэмдэглэгдсэнээр албино бөхөн нас бие гүйцлээ амьдардаггүй. Халимагийн популяцид 1976 оны ангийн улирлын үед 1.5 настай албино эмэгчин тэмдэглэгдсэн нэг мэдээ байдаг (И.А.Погодин, аман мэдээ). Албино бөхөнгийн янзага үхсэн тухай мэдээ бас бий. Хэвийн янзаганы 3.38 болон 3.17 кг жинд харьцуулбал тэдгээрийн дундаж биесийн жин 2.25 (эр), 1.7 (эм) кг тус тус байдаг. Энэ биесийн жингээс үзвэл янзаганы үхлийн эрчим нь 0.8 байдаг.

Бид 2007 оны 5-р сард бөхөнгийн албино янзагыг тэмдэглэсэн. Гүйж яваа бие гүйцсэн эмэгчин амьтдаас 700 мийн зайд цагаан толбо тэмдэглэж ойртон очиход бөхөнгийн эм янзага байгааг ажигласан. Хүйс нь дөнгөж хатсан, ердөө 2-3 өдөртэй янзага байв. Ийм настай хэвийн эмэгчин энэ үед дунджаар 3.46 кг жинтэй, 61.14 см байдаг бол үүний жин 2.4 кг, урт нь 55 см байсан. Янзага бүрэн албино байсан. Түүний нүдний солонгон бурхэвч нь пигментгүй учир нүд нь улаан харагдаж байсан. Бөхөнгийн хэвийн янзаганы туурай хар байдаг бол түүнийх ягаан байсан ба ууцан дээр хар зурvas байгаагүй (зургаас хар). Бид өөр нэг бөхөнгийн албино янзагыг дурандаж харсан боловч түүний нас, хүйсийг тодорхойлж чадаагүй. Ерөнхийдөө албино бөхөнгийн тохиолдол нь 5000-10000 мянгад 1 янзага байдаг (Проняев & Розков, 1988) гэжээ. Харин бидэнд тохиолдсоноор бөхөнгийн албино янзаганд 8000 янзаганд 2 байсан. Бид бие гүйцсэн бөхөнгийн дунд албино тэмдэглэгүй. Бөхөнгийн тоо толгой ялангуяа үргжийн үед тэргүүлж чадах эврийн үнэ цэний төлөөх сонгон агналтын улмаас эрэгчин амьтдын харьцаа буурч байна. Энэ хүчин зүйлтэй холбоотой албино бөхөн илэрч байна гэж бид үзжэй байна.

## Төслийн эргэн тойронд

### Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн

#### Монгол бөхөн тосол

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол бөхөн хэмээх шинэ том төсөл MAVA сангийн дэмжлэгтэйгээр 2007 оны 10-р сард эхэлсэн. Энэ төсөл нь орон нутаг дээр суурилсан мониторингийн программыг нутгийн иргэд, байгаль хамгалагчдад эзэмшүүлэх, ан агууруын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, хамгаалалтын ажилд засгийн газрыг татан оруулах зэрэг ажлуудыг аль хэдийнээ амжилттай хийсэн байна.



Малчдын бүлгүүд хамтын оролцооны аргад  
суралцаж байгаа нь  
Зургийг Б. Чимэддорж



Эко-клубийн хүүхдүүд боловсролын уралдаанд  
Зургийг Б. Чимэддорж



Бөхөн хамгаалагчдын сүлжээ. Зургийг Б.Чимэддорж

Энэ хэрэг цагдаад шалгагдаж байна. 2006 онд баригдсан 54 бөхөн хулгайгаар агнасан хэргийг дахин хянан шалгаад 2007 оны 10-р сард шүүх шийдвэрлэсэн. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь эхний хэргийг үл ойшож байсан орон нутгийн шуугчдийг жагсаалтыг гаргаж, мэргэжлийн бус удирдлагуудыг огцруулахад үүрэг гүйцэтгэсэн. 2008 оны 1-р сарын тооллого судалгаагаар 13000 км<sup>2</sup> нутагт 3240 бөхөн гэж үнэлсэн нь 2007 оныхоос 11.8%-иар ессөн байна. Энэхүү эргэн тойрон дахь явдал нь ердөө баримтууд бөгөөд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэлгэрэнгүй тайлан SCA вебсайтанд хангалттай байгаа. *Илүү нарийн мэдээлэл авбал Б.Чимэддорж, chimededorj@wwf.mn-д холбогдоно уу.*

### Степной дархан газрын үйл ажиллагааны шинэ чиглэл



Ямар нэгэн зэрлэг зүйлийг, ялангуяа их хэмжээгээр агуулурын бай болдог бөхөн шиг цор ганц зүйлийг хамгаалах нь орон нутгийн ард иргэдийн оролцоогүйээр боломжгүй юм. Баруун хойд Каспийн өмнөд бүсийн бөхөнтийн чухал нутгуудын нэг болох Степной дархан газар нь Астрахан мужид оршдог. Энэ дархан газрын ажилчид өдөр шөнөгүй маш шаргуу ажиллаж, популяцийн мониторинг болон эрдэм шинжилгээний судалгааг хэрэгжүүлж байна. Өнгөрсөн цөн жилд тэд зөвхөн бөхөн хамгаалахад төдийгүй (тус нутаг хулгайн ангийн тохиолдол бүртгэгдээгүй) бүс нутгийн биологийн төрөл зүйлийн онгон төрхийг хамгаалахад чухал ач холбогдолтой амжилтанд хүрсэн юм. Мужийн болон бүс нутгийн засаг захиргаа, түүнчлэн PTES, IFAW, LHF гэх мэт манай спонсоруудын дэмжлэгийн ачаар дархан газрын найдвартай хамгаалалтыг бий болгосон байна. Сүүлийн үед дархан газрын ажилчид хамгаалалтын чиглэл рүү давамгайлан өөрсдийн үйл ажиллагааг өргөжүүлэхээр шийдвэрлэжээ. Бөхөн хамгаалах холбооноос жижиг тэтгэлэг авсны үрээр байгуулсан экологийн зам нь Баруун хойд Каспийн бүс дэх энэ жижиг “amar amgalangийn aral”-ын байгальтай бүрэн дүүрэн танилцахаар ирэх зочид (сургуулийн хүүхдүүд, оюутнууд, мужийн албан тушаалтан, Оросын Холбооны улс, далайн чанадын өөр өөр хүрээлэнгүйдээс ирсэн эрдэм шинжилгээний ажилтнууд) байгаль хамгаалахын тулд бидний хүн бүр юу хийж чадахыг илүү сайн ойлгож, амьтны болон ургамлын аймгийн мэдээллийг олж авах боломжийг олгож байна.

Тэнд амарч байгаа болон ярилцах хүмүүст зориулсан газрууд, нөгөө талаас бөхөн байнга ирдэг цэвэрхэн тогтоол уснууд, махчин шувуудад зориулан босгосон хиймэл үүрнүүд бий. Экологийн боловсролын ажил ирээдүйд улам бүр өргөжин хөгжих болно. *Илүү мэдээлэл авахыг хүсвэл Степной дархан газрын Анатоли Хлудневтай limstepnoi@mail.ru хаягаар холбогдоно уу.*



Степной дархан газрын экологийн замын бүдүүвч  
Зургийг Анатолий Хлуднев

### Лондонгийн Эзэн хааны коллежийн төслийн тухай



Манай Дарвины санаачлага байгууллагын Халимагт хэрэгжүүлж байсан “Бөхөн хамгаалалд олон нийтийн оролцооны хандлагыг үнэлэх” тулгуур төсөл 2007 оны 12-р сарын 31-нд дуусгавар боллоо. Энэ төсөл нь сургууль, Буддийн сүм хийдүүд, экологийн боловсролын төвүүд, орон нутгийн засаг захиргаа болон бөхөн хамгаалагчдыг оролцуулан нийгмийн ялгаатай хэсгүүдийн хоорондын холбоог хөгжүүлсэн. Энэ төсөл нь бас бөхөн рүү чиглэсэн хүмүүсийн өөрчлөгдж буй хандлагад бидний хөндлөнгөөс оролцох хамгааллын үр бүтээмжийн үнэлгээнд судалгаа хийсэн. Энэхүү судалгаанаас бидний олж авсан зүйл бүхий эцсийн тайллангийн хуулбарыг биднээс и-мэйл-ээр авч болно. 2008 онд бид “Бөхөнтийн популяцийн экологийн мониторингийн оролцогч” гэсэн нэртэй Их Британи, Оросын их сургуулиудын харилцаа холбоог дэмжихэд чиглэгдсэн Британий зөвлөлийн BRIDGE тэтгэлгийн хүрээнд Халимагийн их сургуультай хамтран ажиллаж байна.

Сургууль бүрээс хоёр оюутан хамтарсан судалгааны төсөл дээр хамтран ажиллаж байна. Нэг төсөл нь төслийн удирдагчаар томилогдсон орон нутгийн хүмүүсийн бөхөнтийн мониторингт оролцох боломжийг ажиглаж байна. Нөгөөх нь Черные Земли Биосфериин судалгаа болон Степной дархан газарт хэрэгжүүлж буй бөхөнтийн удаан хугацааны мониторингийг сайжруулахад, мөн шинжлэх ухаан болон хамгаалалд хамгийн их ач холбогдолтой мэдээллийг батлахад чиглэгдэж байна. Бид Казахстаны Амьтан судалалын хүрээлэн болон бусадтай хамтран бүхий л хугацаанд бөхөнтийн тархалтыг тодорхойлох хүчин зүйл болох ландшафтын түвшинд авч үзэх шинэ төслийг эхлүүлэхээр зэхжэй байна. Энэ төсөл нь Леверхульм сан болон Лондонгийн Роял нийгэмлэгээс санхүүжилтээ авах болно. Эдгээр төслийн тухай ишүү нарийн мэдээллийг авахыг хүсвэл Е.Ж.Милнер-Гулландтай [e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk) хаягаар холбогдоно уу.



WILDLIFE CONSERVATION NETWORK

WCN-ээс санхүүждэг Бөхөн хамгаалах холбооны баг нь хэдэн жилийн турш Устюорт, Узбекистаны хүүхдүүдэд боловсролын хөтөлбөрийг аль хэдийнээс хэрэгжүүлсэн билээ. Хулгайн ангийн түвшин өндөр байdag тосгоны (Яшлик, Каракалпак) гурван сургуулийн багш, хүүхдүүд, түүгээр зогсохгүй тэдгээрийн эцэг эхчүүд бөхөн хамгаалах хөтөлбөрийн идэвхитэй хэсэг болж байна. Устюортийн тэгш өндөрлөгийн зүүн хэсгийн алслагдсан районд орших (Кубла-Устюорт) шинэ тосгоноос ирсэн сургуулийн хүүхдүүдийг оролцуулнаар манай хөтөлбөр улам бүр өргөжсөөр байна. Бөхөнгийн тухай урлагийн тоглолт сургуулиуд дээр 2008 оны 3-4-р сард болсон. Хүүхдүүдийн, багш нарын, эцэг эхчүүдийн нилээд их ажил, урлагийн тоглолтонд орсон. Хүүхдүүд бөхөнгийн тухай түүх: шидэт үлгэр, богино өгүүлэлгээ, шүлэг бичсэн. Шүүгчдийн бүрэлдэхүүнээс сонгон авсан хамгийн сайн түүхийг урлагийн тоглолтын тухай киног хийхэд ашиглажээ.



#### Яшикли тосгон дахь бохонгийн урлагийн тоглолт.

Бүх хувцас, чимэглэсэн яшикли тоглолт дахь бохонгийн урлагийн тоглолтадаа туслахад тоглож байсан. Жишигийн 56-р сургуулийн хүүхдүүд жүжгийн хүүхэлдэй хийсэн байна. Хүүхэлдэйнээс авахуулаад бөхөнгийн өдөр тутмын амьдралыг харуулсан зургаар чимэглэсэн тайзыг хүртэл сургуулийн хүүхдүүд хийсэн. Каракалпакийн 26-р сургуулийн сурагчид хэдэн эрэлхэг зоригтой хөвгүүд бөхөнгийн янзагыг хулгайн анчдаас аварч байгаа тухай детектив түүхийг хийсэн байв. Яшилийн 54-р сургуулийн урлагийн тоглолт хөгжим, бүжиг, дуу, шүлэг бүхий жинхэнэ баар болон хувирсан. Хүүхдүүдийн бичсэн түүхүүд бүгд нутгийн уламжлал, ардын аман зохиолын мэдлэг авьяасыг харуулсан, гүнзгий сэтгэгдэл төрүүлэхүйц, маш сэтгэл хөдөлгөм болсон.

#### Устюортын эмэгтэйчүүдийн нэмэлт орлогын

##### Эх үүсвэр болох уламжлалт хатгамал



Бөхөн хамгаалах холбоо 2008 оны 4-р сард WCN-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Аралын алтан өв” төрийн бус байгууллагатай хамтран Устюортын (Узбекистан) эмэгтэйчүүдэд зориулан Каракалпакийн уламжлалт хатгамалын тухай боловсролын программыг санаачилсан. Үүний гол зорилго бол бөхөнгийн амьдрах орчинд ойрхон амьдарч байгаа эмэгтэйчүүдэд нэмэлт орлогын эх үүсвэрийг бий болгосноор бөхөн хамгаалалд туслах явдал юм. Гэрийн эзэгтэй нар гэр бүлийн санхүүгийн бодлого, сэтгэлгээг тодорхойлдог нь нууц биш юм. Харьцаангуй хямд үнэтэй учраас эрэлт хэрэгцээ өндөртэй байdag бөхөнгийн махны гол худалдан авагч нь тэд юм. Узбекистанд эдийн застгийн байдал хүндэрсэн учраас олонх эмэгтэйчүүд тогтмол ажил байдагтгүй. Орлогын эх үүсвэрийн



Каракалпак тосгон дахь жүжгийн хүүхэлдэйн сургууль  
Зургийг Александр Эсипов

Харамсалтай нь тэдний хэсэгхэн нь урлагийн тоглолтын талбайд тогlossen. Ирэх жил бид өөрсдийн ажлаа Узбекистаны хүүхдүүдийн бичсэн бөхөнгийн тухай шидэт үлгэрийн ном бэлдэхийн тулд багш нартай үргэлжлүүлэн ажиллах төлөвлөгөөтэй байна. Энэ нь хүмүүсийн бөхөн рүү болон байгаль руу хандах хандлагыг өөрчлөхөд өрөнхийд нь туслах болно гэдэгт бид бат итгэлтэй байна. Энэ нь зөвхөн уламжлалт агнуурын зүйл төдийгүй үндэсний өв, нутгийн соёлын нэг хэсэг болох бөхөн рүү хандах насанд хүрэгчдийн-эцэг эх, ах, эгч нарын хандлагыг өөрчлөх болон өсвөр үеийн хүмүүжлийг бий болгоход хүчтэй түлээц өгөх болно. Цаашдын мэдээллийг авахыг хүсвэл SCA-ийн Елена Быкова болон Александр Есипов наратай [esipov@sarkor.uз](mailto:esipov@sarkor.uз) наратай холбогдоно уу.



Кубла-Устюорт тосгон дахь урлагийн тэмцээний ялагчдыг шагнаж байгаа нь  
Зургийг Александр Эсипов

сонголтыг тэдэнд олгохын тулд уламжлалт гар урлал-хатгамалыг сургах санал оруулсныг бид шийдвэрлэсэн. Эрт үээс эхлэн энэ бус нутагт хатгамалаар чимэглэсэн баян тансаг гэрийн эд зүйлс, хувцанд тэдгээр хүмүүсийн хувийн онцлог байдлыг илтгэсэн ер бусын, маш үзэмжтэй эд өлгийн соёл хөгжжэ. Энэ ердийн тортон дээр гар аргаар хийсэн хатгамал нь хүн болон байгалийн амьдралыг тусган харуулсан, гүн гүнзгий билэгдлэтийг байжээ. Уран хатгамалчид орон нутгийн хүмүүсийн амьдралын уламжлалын замнал, цаг хугацааны өөрчлөлтийн тухай өгүүлсэн амьтан ургамлын зураг байдлаар язлан бий болгожээ. Үнэндээ тэдгээрийн өнгө болон хээний сонголт чамин байдал нь илүү хянамгай хийсэн хатгамалыг олоход



хэцүү байдаг. Энэ төслийг хэрэгжүүлэхд тусгайлсан багаж хэрэгсэл, илүү зарлага шаардагдахгүй, тэсвэр тэвчээртэй, чухамдаа уран сэтгэмжтэй эмэгтэй хүн бүр энэ ажлыг гэртээ хийж чадна. Хамгийн сүүлд энэ төсөл Яшлик тосгон дээр төвлөрөн нэг жилийн турш ажиллах болно. Бид сургалтын өрөө бэлдэж, сургалтыг хүлээн авахаар сонирхож байгаа эмэгтэйчүүдийн бүлгийг тэндээ цуглуулан, орон нутгийн улирдагчийг сонгосон байгаа. Урьдчилсан хичээл хийгдэж, чанар сайтай анхны бүтээгдэхүүнүүд аль хэдийн хийгдсэн байна.

Цаашдаа хичээл нь хатгамалын элемент рүү чиглэн улам хүндрэх бөгөөд бид бүтээгдэхүүнийг худалдах туршилтаа эхлэх болно. Бид мөн бөхөн хамгааллыг дэмжихэд ашиглахын тулд бөхөнгийн зургийг уламжлалт хэв маягт оруулан бүтээх төлөвлөгөөтэй байгаа. Цаашидын мэдээллийг авахыг хүсвэл *SCA-ийн Елена Быкова* рүү [esipov@sarkor.uз](mailto:esipov@sarkor.uз), Арагын Алтан өвийн Гулнара Эмбергенево рүү [altnyl@rol.uз](mailto:altnyl@rol.uз) хаягаар хандана уу.



### Узбекистанд бөхөнгийн дархан цаазат газрыг

#### ҮНЭЛЭХ ШИНЭ ТӨСӨЛ ЭХЭЛЛЭЭ

Узбекистанд бөхөнд зориулсан “Сайгачий” гэж нэрлэгдэх дархан цаазат байгаа боловч зөвхөн “цаасан дээр” байна. Энэ газрын зорилгыг тодорхойлж, статусыг дээшлүүлэх хэрэгтэй байгаа юм. Шинэ дархан газарт удаан хугацааны хамгаалалт болон бус нутгийн хөгжлийн хоорондох газар ашиглалтыг маш сайн дүйцүүлэн гаргаж, биологийн төрөл зүйлийг хамгаалах олон янзын аргыг бий болгох зайлшгүй шаардалагатай. Үүний салшгүй хэсэг болох орон нутгийн хүн амын шууд оролцоотой ажиллах ёстой.

Сайгачий дархан цаазат газрыг 1991 онд 1 сая га талбайтайгаар бөхөнгийн төллөдөг нутгуудыг хамгаалахын тулд тусгайлан байгуулж байсан. Гэвч дэд бүтэц, тээвэр болон ажилчдын орон тоо хангалтгүй учраас одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулаагүй байна. Ойролцоо амьдардаг орон нутгийнхан үүний тухай юу ч мэддэггүй байна. Иймд дархан цаазат газрыг илүү үр дүнтэй хэлбэрээр дахин зохион байгуулах шаардлагатай юм. 2008 оны 4-р сард Бөхөн хамгаалах холбоо Олон улсын ургамал амьтдын сан, Орос Узбекстаны амьтан судлалын хүрээлэн, Диснейн Зэрлэг амьтдын сан, Зэрлэг амьтан ажиглагчдын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр тусгай хамгаалалттай нутагт Сайгачий дархан цаазат газрыг илүү үр дүнтэйгээр дахин зохион байгуулахад бэлтгэн, шинэ төслийг эхэлсэн.



**Эхний алхам. Яшлик тосгон дахь хатгамалын сургалт**  
Зургийг Александр Есипов



**Сайгачий тусгай хамгаалалттай газрын хугархай самбар.**  
Зургийг Александр Есипов

Төслийн баг Узбекистан дахь бөхөн хамгаалах идэвхтэй механизмын дотор энэ “цаасан дээрх дархан газрын” өөрчлөлтийн эхний үе шат болох бөхөнгийн үржих нутаг, нүүдлийн замыг үр дүнтэй хамгаалахын тулд Устюртын тэгш өндөрлөг дэх хил дамжсан тусгай хамгаалалтай газрыг байгуулах урьдчилсан нөхцлийг бий болгож байна. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Александр Есипов & Елена Быкова рүү [esipov@sarkor.uз](mailto:esipov@sarkor.uз), Ричард Эльхорн рүү [RicharaAllhorn@fauna-flora.org](mailto:RicharaAllhorn@fauna-flora.org) хаягаар хандана уу.



## Сүүлийн үед хэвлэгдсэн бөхөнгийн талаарх НИЙТЛЭЛИЙН ТОЙМ

Абатуров Б.Д. Оросын бөхөнгийн популяци, түүний хамгааллын асуудлууд. *Вестник Российской Академии Наук [Оросын Шинжлэх ухааны академийн сэтгүүл]*, 2007, цуврал 77, №9, 785-793 х.

Аливаа хамгаалалт нь шинжлэх ухааны нарийн судалгаанд сууриссан байх ёстой гэсэн санааг илрэхийлжээ. Тэгтэл энэ хандлагаас хэлтийсэн бодит зураглал нь чухамдаа хуулиас гадуурх зүйл юм. Бөхөнгийн тоо толгойн хандлагын анализ дээр үндэслэн зохиогч аливаа амьтны хамгаалалд зөвхөн шууд хамгаалалт төдийгүй хүний үйл ажиллагааны хяналт болон амьдрах орчныг хамгаалах арга хэмжээний харицсан хамаарлын тогтолцоо шаардлагатай гэдгийг харуулжээ.

Арилова Н.Ю. Оросын бөхөнг хамгаалъя!. Экологи, амьдрал. № 1 (74), 2008, х.60-65.

Өнөөдөр бөхөнгийн хувь тавилан мөхлийг ирмэгт ойрхон байна. Агналтыг бүрэн хориглосон ч Халимагийн бөхөнгийн нөөц өнгөрсөн 10 жилд 90%-иар буурчээ. Орон нутгийнхан болон мэргэжилтнүүдийн судалгаагаар үүний шалтгаан нь хулгайн ан, амьдрах орчны алдагдал, нүүдлийн зам дахь саад, чоно, хээрийн түймэр болохыг илрүүлжээ. Гэсэн хэдий ч хулгайн ан бол үндсэн шалтгаан бөгөөд популяцийн нөхөн сэргэхэд саад учруулах гол түлхүүр юм. Зохиогч олон улсын болон үндэсний тувшинд аль алинд нь бөхөн хамгааллын ялгаатай жишээг иш татаад хэрвээ орон нутгийн иргэд, байгаль хамгаалах байгууллага, хууль сахиулах товчоо бүгд энэ өвөрмөц зүйлийг хамгаалахаар хамтран зогсож чадвал бөхөнг хамгаалж чадах болно гэдгийг цохон тэмдэглэжээ.

Клевезаль Г.А. Хөхтөн амьтдын насыг тодорхойлох арга зүй, зарчмууд. Москва: КМК ШУ-ны сэтгүүл. 2007.283 х.

Энэ номыг уншигчид хөхтөн амьтдын нас тодорхойлох үндсэн аргуудыг мэдэх болно. Номын эхний хэсэгт тэдгээрийн задрах шинж тэмдэг, давуу тал болоод дутагдалтай тал, хэрэглэх орон зай зэргээр өөр хоорондоо ялгаатай аргуудыг тодорхойлжээ. Амьд амьтдын насыг тодорхойлоход онцгой анхаарал хандуулжээ.

## Зарлал

### Бөхөн хамгаалах холбооны жижиг тэтгэлгийн

#### хөтөлбөр 2008



Бид Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнээс санхүүжин 2008 онд хэрэгжих Бөхөн хамгаалах нийгэмлэгийн Жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг зарлаж байгаадаа баяртай байна. Хөтөлбөрийн зорилго нь сонгон авсан нутаг дахь бөхөн хамгаалах жижиг хэмжээтэй, богино хугацааны төслүүдэд боломж олгоход чиглэглэх бөгөөд өөр зүйлийг санхүүжүүлэхгүй болно.

Төслийн шаардлага нь:

- Байгаль дахь (уржүүлгийн нөхцөлд биш) бөхөнгийн хамгаалалтай холбоотой байх
- Бөхөнгийн өнөөгийн байдалд илэрхий болон шууд нөлөөтэй байх
- Хамгийн их нь 1 жилийн хугацаатай байх (2009 оны 11 сарын сүүлч гэхэд дууссан байх)
- Төсвийн хэмжээ 1000\$-2000\$-ийн хооронд байх
- Томоохон төслийн жижиг бүрдэл хэсгээс илүүтэйгээр илт биеэ даасан байх
- Бөхөн хамгаалах холбоонд элссэн, үүний хуулийн хэм хэмжээний хүрээнд тавигдсан болзлын дагуу тайлagnадаг байх

Та бүхэн илүү тодорхой мэдээлэл болон өргөдлийн маягтыг [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com), эсвэл [esipov@sarkor.uz](mailto:esipov@sarkor.uz), [saiqaconservationalliance@yahoo.co.uk](mailto:saiqaconservationalliance@yahoo.co.uk) хаягаар хандан е-майл-ээр авч болно. 2008 оны 9-р сарын 30-ны өдөр өргөдөл хүлээн авах хугацааг хаах бөгөөд төсөл 2008 оны 11-р сарын 15-наас нэг жилийн хугацаатай үргэлжилнэ.



Орос, Степной дархан газрын бөхөн  
Зургийг Анна Лущекина



# Бөхөн хамгаалах холбоо бөхөнгийн хамгааллын харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг үнэлж байна

**Харилцан ойлголцлын санамж бичгийн 2008 оны I-VI-р сарын хугацаанд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан**

*Тайланг БХХ-д зориулан Э.Ж.Милнер-Гулланд эмхтгэв*

## Дүгнэлт

Энэ тайлангийн хугацаанд бөхөн хамгаалалд сайн дэвшил гарлаа. Тайлангийн ажлын чанар болоод стандарт харьцангуй сайжирсан нь бид илүү үр дүнтэй амжилтыг гаргаж чадсан гэсэн үг юм. Узбекистан болон Халимагт санхүүжүүлэгч нар төслөө үргэлжлүүлэн мөн шинэ төслийг дэмжсэнээр хэдэн шинэ төсөл эхэллээ. MAVA-гийн санхүүжилтээр Монголд эхэлсэн шинэ томоохон төслийг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар зохицуулж байгаа бөгөөд өмнөө тавьсан бодитой, ялангуяа хулгайн ан, олон нийтийн сонирхол татах зэрэг ажлуудын тоогоор тэргүүлж байна. Хятадад хийгдсэн хуулийн шинэ зүйл анги нь эвэр цуглулахад нөлөөлж байсан томоохон цоорхойг хаасан. Казахстанд бөхөн хамгаалах үйл ажиллагаа үргэлжилсээр байна. Энэ тайлангийн хугацаанд Туркменистанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай мэдээлэл бидэнд байхгүй байна. Хамтарсан үйл ажиллагааны хөтөлбөрийн хэд хэдэн үйл ажиллагааны чиглэлийг, ялангуяа өмнөх тайлан дахь A1 (эхний ээлжний, чухал)-д дурдсан үйл ажиллагаатай холбоотойгоор хийгдсэн бага зэргийн харагдахуйц үйл ажиллагааг энэ тайлангийн хугацаанд орууллаа. Эдгээр үйл ажиллагаанууд нь хамгийн түрүүнд тавигдааар байх уу, үгүй юу гэдгийг тодруулан, хэрвээ тийм бол ХОСБ-ийн дараагийн уулзалтыг үүнд амжилт гаргахад чиглүүлэх зайлшгүй шаардлагатай. A1-ийн үйл ажиллагааны бодитой бус амжилтуудыг урьдчилсан байдлаар харуулж байна.

*Үйл ажиллагаа 1.1. Орос ХОСБ-нд гарын үсэг зурж байна.*

*Үйл ажиллагаа 3.1. Орос, Казахстан CITES-тай зөвлөлдөн экспортын нийлүүлэлтээ хааж байна.*

*Үйл ажиллагаа 9.1/14.2. Монголд зориудаар өсгөн үргүүлэх боломжийг бий болгож байна.*

*Үйл ажиллагаа 11.2. Уралын бөхөнгийн популяцийг хамгаалахын тулд олон нийтэд сурталчилгаа хийж, тэдгээрийг татаж байна.*

*Үйл ажиллагаа 11.3. Уралын популяцийн хамгааллыг төлөвлөж байна.*

Хамтарсан үйл ажиллагааны хөтөлбөр дахь A1-ийн бусад үйл ажиллагаанууд нь зарим улсын хэмжээн дэхь хэд хэдэн үйл ажиллагаанууд байна. Ерөнхийдөө энэ нь MOU-д гарын үсэг зурсан талуудын дараагийн уулзалтын өмнө MTWP-ийн биелүүлэх зорилго өөд гаргасан урам хайрласан амжилт юм.

Бүрэн тайлан <http://www.saiga-conservation.com/mou.html>, хаяг дотор бэлэн байгаа. Та бүхэн 2008 оны VII-XII сар хүртэл хугацаан дахь өөрсдийн хийсэн ажлын тайлангаа **2008 оны XII сарын 15-ны дотор** илгээнэ үү. Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, он сар, санхүүжүүлэгч, багаж хэрэгслийн тухай боломжийнхоо хирээр онцлоно уу. Өмнө нь мэдээлэгдсэн юмуу тэдгээр нь хараахан эхлээгүй байгаа үйл ажиллагаа хамарагдахгүй болно. Хэрвээ төсөл үргэлжилж байгаа бол энэ хугацаанд ямар үйл ажиллагааг үргэлжлүүлж байгаа, тэдгээр төслүүдийн ажлын хүрээнд хийгдсэн онцлог үйл явдлыг товч дурдана уу.

## Талархал

Бөхөн хамгаалах холбоо бидний үйл ажиллагааг ивээн тэтгэсэн доор дурдсан хувь хүн, хандивлагч наарт чин сэтгэлийн талархлаа илэрхийлэхэд таатай байна: Мэггие Брайан, Вэнс Мартин, Зэрлэг амьтдын сан, Жуди ба Чак Витлей, Кенном болон Боб Хадсон, Линда Тэбор-Бек, Майкл Хакетт, Жефф Флокен, Энни Мария Бургуоне, Брэд Робертс, Гloria болон Кэнт Маршалл, Стивен болон Кэрин Чэйси, Гэвин Эванс, Кэрол Энн Ходжес, Жессика Келеур болон бусад хүмүүс бөхөн хамгаалах ажил хэрэгт маш их тус хүргэсэн юм. Бид энэхүү цувралыг ивээн тэтгэсэн WCN, CMS, FZS болон Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар зэрэг байгууллагуудад талархаж байна.